



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Аудитын тайлан

ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ БУУРУУЛАХАД ДЭМЖЛЭГ БОЛОХУЙЦ ҮР АШИГТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРЭН БҮРДЭЭГҮЙ, ЦОГЦ БОДЛОГОГҮЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ, ҮР ДҮН
/2018-2020 онд ашигласан гадаад зээл, тусламжийг хамруулав./

АУДИТЫН КОД: АГГ-2021/10/ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд

Утас: 263755, цахим хаяг: enkhbold@audit.gov.mn

Аудитын менежер Б.Долгорсүрэн

Утас: 261805, цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn

Ахлах аудитор И.Туяадарь

Утас: 262451, цахим хаяг: tuyadariib@audit.gov.mn

Аудитор М.Баяртогтох

Утас: 262451, цахим хаяг: bayartogtokhm@audit.gov.mn

Аудитор Б.Булган

Утас: 262451, цахим хаяг: bulganb@audit.gov.mn

Аудитор Ц.Цолмон

Утас: 262451, цахим хаяг: tsolmonts@audit.gov.mn

Аудитор Э.Уянга

Утас: 262451, цахим хаяг: uyangae@audit.gov.mn

Аудитор Х.Энх-Амгалан

Утас: 262451, цахим хаяг: enkhambalankh@audit.gov.mn

Улаанбаатар хот
2021 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/93

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар /Б.Бундхорол/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монголбанк, Сангийн яаманд хүргүүлэхийг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т тус тус даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд /Л.Оюун-Эрдэнэ/, Монголбанкны ерөнхийлөгч /Б.Лхагвасүрэн/, Сангийн сайд /Б.Жавхлан/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч, тэргүүлэх аудитор /Я.Сарансүх/-т даалгасугай.

5. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын гуравдугаар газар /Д.Энхболд/-т даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг /И.Туяадарь/-т үүрэг болгосугай.




Д.ЗАНДАНБАТ

Z:\Tushaa\2021\EA-In A Tushaal\1011 Auditin 3-R Газарт Docx

001011021

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны
10 дугаар сарын 1-ны өдрийн 33 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Аудитаар тогтоосон төлбөрийн акт,
албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчил хариуцах		Төлбөр, зөрчлийн товч утга	Дугаар	Төлбөрийн актын дүн	/сая төгрөг/ Албан шаардлагын дүн
	Байгууллага	Албан тушаал				
1	БХБЯ	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	Төслийн хүрээнд ашиглалтад оруулсан барилга байгууламжийг хөрөнгөд бүртгээгүй.	647/АО170114 АГГ-2021/10/ШТА-ГА	-	54,914.4
2	ЭМЯ	Хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга	Төслийн хүрээнд худалдан авах тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй байхад төлбөр шилжүүлсэн.	648/АО170114 АГГ-2021/10/ШТА-ГА	-	847.4
Нийт						55,761.8

АГУУЛГА

Хүснэгт, график, дүрслэлийн жагсаалт	6
Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа	7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	9
БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛЭЭР САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙНА	11
Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг сонгох, үнэлэх, эрэмбэлэх аргачлалгүй бөгөөд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх бусад эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байна.....	11
Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн нь төсөл, арга хэмжээ удаашрах нөхцөлийг бүрдүүлж байна	12
Тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан санхүүжилтийг хэтрүүлэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.....	14
Засгийн газрын гадаад зээлийн тодорхой бодлогогүйгээс гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний зорилт үр дүнгүй болох эрсдэлтэй байна	14
Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна	18
Дотоодод дамжуулсан зээлийн 47.0 хувь нь эргэн төлөгдөөгүй байна	20
Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулж байна.....	22
Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийн 59.1 хувийг гадаад зээл эзэлж байгаа нь ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байна	24
Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн мэдээллийн нээлттэй, ил тод байдал хангалтгүй байна	25
Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдэд тавих хяналт хангалтгүй байна	25
БҮЛЭГ 2. ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙН БҮРТГЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	27
Хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилт, үр дүнг тооцох аргачлал байхгүй, зохицуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна.....	27
Сангийн яаманд зарим тусламжийг бүртгээгүй байгаагаас өөр эх үүсвэрээс төсөл, арга хэмжээ давхар санхүүжих эрсдэлийг бий болгож байна	27
Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хянаж үр дүнг тооцоогүй байна	29
Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна	29
Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр коронавируст (Ковид-19) цар тахалд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр дүнг тооцоогүй, судалгаанд суурилсан санхүүжилт хийхгүй байна	30
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	33
ДҮГНЭЛТ	38
ЗӨВЛӨМЖ	40
ХАВСРАЛТУУД	42
Хавсралт 1. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт /салбараар, тэрбум төгрөг/	42
Хавсралт 2. Гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтын хувь /салбараар/	43
Хавсралт 3. 2018-2020 онд тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан төсвийг хэтрүүлэн ашигласан төсөл, арга хэмжээний жагсаалт	43
Хавсралт 4. Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн байдал /сая төгрөг/	45
Хавсралт 5. Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн эргэн төлөгдөөгүй зээлийн 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл	45
Хавсралт 6. Эрүүл мэндийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, үр дүнг /сая төгрөг/	47

Товчилсон үгсийн тайлал

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
АЗБХЗГ	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЕХОБ	Европын хөрөнгө оруулалтын банк
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТБХБЯ	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НӨАТ	Нэгдсэн өртгийн албан татвар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОСНААУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
ОУВС	Олон улсын валютын сан
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
СБХБ	Сэргээн босголт хөгжлийн банк
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУХ	Төслийн удирдах хороо
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
УИХ	Улсын Их Хурал
УХОХ	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНН	Хувь нийлүүлсэн нийгэмлэг
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДҮС	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
ЯОУХАА	Японы Олон улсын Хамтын ажиллагааны агентлаг

Хүснэгт, график, дүрслэлийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1	Засгийн газрын өрийн үлдэгдэл /тэрбум төгрөг/	10
Хүснэгт 2	Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл /тэрбум төгрөг/	11
Хүснэгт 3	Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт гүйцэтгэл /тэрбум төгрөг/	14
Хүснэгт 4	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зээлийн хөдөлгөөн /тэрбум төгрөг/	22
Хүснэгт 5	Төсвийн алдагдал, төсвийн алдагдлыг нөхөх зээлийн харьцуулалт /тэрбум төгрөг/	22
Хүснэгт 6	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн шилэн дансны бүртгэл хөтөлөлтийн хувь	25
Хүснэгт 7	Засгийн газрын гадаадын зээлийн ашиглалтыг мэдээлсэн байдал /тэрбум төгрөг/	25
Хүснэгт 8	Тусламжийн төрөл 2018-2020 оны ашиглалт /тэрбум төгрөг/	29
Хүснэгт 9	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн шилэн дансны бүртгэл хөтөлөлтийн хувь	30
Хүснэгт 10	Цар тахлын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэл /тэрбум төгрөг/	30
Хүснэгт 11	Гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлсэн цар тахалтай тэмцэх төсөл, арга хэмжээний судалгаа	31

Графикийн жагсаалт

График 1	Гадаад зээл, санхүүжүүлэгч байгууллагаар /1991-2020 он/	9
График 2	Нийт өрийн бүтцэд эзлэх гадаад зээлийн эзлэх хувь /тэрбум төгрөг/	10
График 3	Гадаад зээлийн үлдэгдлийн өсөлт /тэрбум төгрөг/	10
График 4	Гадаад тусламж, санхүүжүүлэгч байгууллагаар /2018-2020/	10
График 5	Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт, салбараар	15
График 6	Тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн гадаад зээлийн санхүүжилтийн хувь	15
График 7	Дамжуулан зээлийн эргэн төлөлт /тэрбум төгрөг/	20
График 8	Эргэн төлөлт хийгээгүй дамжуулан зээлийн үлдэгдэл /тэрбум төгрөг/	21
График 9	Нэгдсэн төсвийн тэнцэл ба төсвийн алдагдлыг нөхөх зээлийн ашиглалт /тэрбум төгрөг/	23
График 10	ДНБ-д нийгмийн зардлын эзлэх хувь	23

Дүрслэлийн жагсаалт

Дүрслэл 1	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл /тэрбум төгрөг/	12
-----------	---	----

Аудит хийсэн үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ. Үүнд:

- ✓ Засгийн газрын шугамаар олон улсын байгууллагаас авсан зээлийг үр дүнтэй ашигласан эсэх;
- ✓ Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн ашиглалт үр дүнтэй эсэх;

Аудитыг Засгийн газрын гадаад зээл, тусламжийн байдал, түүнд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн судалгаа, шинжилгээ, тайлан, төслийн нэгжийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангууд, дамжуулан зээлд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын зээлтэй холбогдох үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, бусад нотлох баримт материалд үндэслэн 2018-2020 онд хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан гадаад зээл, тусламжийн ашиглалтыг хамруулан гүйцэтгэв.

Аудитад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийг ашиглаж буй төсвийн ерөнхийлөн захирагчид, орон нутгийн засаг, захиргааны нэгж, дамжуулан зээл авсан аж ахуйн нэгж, байгууллага болон бусад холбогдох байгууллагын 2018-2020 оны үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000, “Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS6817:2020”, АДБОУС 5400-5499 Улсын өрийн аудитын удирдамж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан шалгагдагч байгууллагын ажил хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асууж тодруулах болон судалгаа авах, тулган баталгаажуулах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын шалгуур үзүүлэлт

Асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан төлөвлөсөн арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлтэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг аудитад шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Өрийн удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Валютын зохицуулалтын тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт;

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт;
- Улсын өрийн аудитын удирдамж /АДБОУС 5250/;
- Монгол Улсын Их Хурлын 2019 оны 55 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”;
- Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”;
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Аудитын зорилго, зорилтод шаардагдах бодлогын болон хууль, эрх зүйн бусад баримт бичгүүд.

Аудитын баг, бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Х.Баярмаа, Б.Долгорсүрэн нар үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор И.Туяадарь, аудитор М.Баяртогтох, Б.Булган, Э.Уянга, Ц.Цолмон, Х.Энх-Амгалан, Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудиторуд /Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжсэн төсөл арга, хэмжээний хэрэгжилтийг шалгасан/ төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл:

Аудитын явцад дэлхий нийтийг хамарсан коронавируст (Ковид-19) цар тахлын дэгдэлт ихсэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин Төрийн захиргааны төв байгууллага, агентлагууд албан хаагчдын 30 хүртэл хувийг ажиллуулах, хатуу хөл хорио тогтоох зэрэг арга хэмжээ авснаар албан хаагчид цахимаар ажилласан тул талбарын үе шатны ажлыг шалгагдагч байгууллага дээр очиж, анхан шатны баримт материалтай танилцах боломжгүй болсноос шаардлагатай баримт материал, судалгааг цахимаар хүлээн авахад хугацаа алдах, хүлээлт үүсэх, авсан баримтууд шаардлага хангахгүй байх, ажил хариуцсан албан хаагчид ажлаас гарснаас шалтгаалан зарим баримт, судалгаа авах боломжгүй болох зэрэг хүндрэл, бэрхшээл үүссэн болно.

Аудитын материаллаг илрүүлэлт

Аудитаар нийт 5,449.3 тэрбум төгрөгийн 14 зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 55.7 тэрбум төгрөгийн 2 албан шаардлага, 5,393.5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өглөө.


ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹ дэх хэсэгт 7 төрлийн зориулалтаар өр үүсгэж болно гэж зааснаас тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т “Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх”, 12.1.5-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх” заалтуудыг тус тус үндэслэн хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна.

Манай улс 1991-2020 онд хандивлагч орон, олон улсын байгууллагатай 267 гэрээ байгуулж, нийт 6,887.9 сая ам.доллар буюу 19,706.1 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашиглажээ. Нийт гадаад зээлийн 27.3 хувь буюу 1,883.8 сая ам.доллартой тэнцэх 5,389.4 тэрбум төгрөгийн 302² гэрээг байгуулж, дотоодод дамжуулан зээлдүүлсэн байна.

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан нийт гадаад зээлийн 82.2 хувь буюу 16,190.8 тэрбум төгрөгийг АХБ, ЯОУХАА, БНХАУ, Дэлхийн банкнаас авч ашиглажээ. /График 1/

График 1. Гадаад зээл, санхүүжүүлэгч байгууллагаар /1991-2020 он/



■ АХБ ■ ЯОУХАА ■ БНХАУ ■ ДБ ■ Бусад
Эх сурвалж: Сангийн яам

Гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтыг салбараар ангилж үзвэл зам, тээврийн салбарт 17.3 хувь буюу 3,401.0 тэрбум, эрчим хүчний салбарт 14.4 хувь буюу 2,837.7 тэрбум, төсвийн дэмжлэгт 13.2 хувь буюу 2,606.8 тэрбум, хөдөө аж ахуйн салбарт 11.8 хувь буюу 2,333.9 тэрбум, бусад салбарт 43.3 хувь буюу 8,526.7 тэрбум төгрөг байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү./

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас 2018 онд 590.7 сая ам.доллар буюу 1,482.1 тэрбум, 2019 онд 610.2 сая ам.доллар буюу 1,638.6 тэрбум, 2020 онд 1,195.0 сая ам.доллар буюу 3,368.4 тэрбум, нийт 2,395.9 сая ам.доллар буюу 6,489.1 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, ашигласан байна.

Сүүлийн 3 жилд авсан нийт зээлийн АХБ-аас 35.7 хувь буюу 2,316.8 тэрбум, БНХАУ-аас 20.3 хувь буюу 1,316.5 тэрбум, ЯОУХАА-аас 15.3 хувь буюу 991.3 тэрбум, Дэлхийн банкнаас 8.8 хувь буюу 572.6 тэрбум, бусад хандивлагч орон, олон улсын байгууллагаас 19.9 хувь буюу 1,291.9 тэрбум төгрөгийг тус тус авч ашиглажээ. Энэ хугацаанд урд онуудаас эхэлсэн төсөв, санхүүгийн хүндрэлтэй үе таарч ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд тус сангаас 1,327.7 тэрбум төгрөгийн³ төсвийн дэмжлэг авсан байна.

Нийт гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн дэмжлэгт, 16.5 хувийг зам, тээврийн, 7.2 хувийг эрчим хүчний, 5.3 хувийг усан хангамж, хотын дэд бүтцэд, 4.6 хувийг эрүүл мэндийн, 2.5 хувийг боловсролын салбарт тус тус зарцуулсан байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2018 онд нийт өрийн 50.1 хувийг, 2019 онд 52.9 хувийг, 2020 онд 59.1 хувийг эзэлж, жилээс жилд нэмэгдсээр байна. /Хүснэгт 1, График 2/

Энэ нь ханшийн өөрчлөлт болон Засгийн газраас дотоод үнэт цаасны арилжааг зогсоож, зарим дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авч, хэмжээг бууруулсантай холбоотой байна.

¹12.1. Засгийн газар дараах зориулалтаар өр үүсгэж болно:

12.1.1. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх.

12.1.2. төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх.

12.1.3. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг дэмжих.

12.1.4. Өрийг дахин санхүүжүүлэх.

12.1.5. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх.

12.1.6. Улсын төлбөрийн тэнцлийг дэмжих зорилгоор Монголбанкны гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

12.1.7. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хуульд заасны дагуу төрөөс банкнийг дахин хөрөнгөжүүлэх

² Нэг үндсэн зээлдэгчээс хэд хэдэн зээлдэгчид дамжуулан зээлдэгчтэй гэрээ байгуулж болно.

³ 2018 онд 474.9 тэрбум төгрөг, 2019 онд 408.1 тэрбум төгрөг, 2020 онд 445.2 тэрбум төгрөг.

Хүснэгт 1. Засгийн газрын өрийн үлдэгдэл


Өрийн бүтэц	/тэрбум төгрөг/		
	2018.12.31	2019.12.31	2020.12.31
I. Засгийн газрын дотоод өр	1,564.7	1,399.6	1,136.6
1.1 Үнэт цаас	1,564.7	1,399.6	1,136.6
II. Засгийн газрын гадаад өр	18,865.6	20,728.1	24,851.4
2.1 Үнэт цаас	7,664.5	7,927.2	8,354.0
2.2 Гадаад зээл	11,201.1	12,800.9	16,497.4
III. Засгийн газрын өрийн баталгаа	1,130.7	1,076.3	1,060.4
IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс	806.0	995.7	850.2
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III+IV)	22,367.0	24,199.7	27,898.6
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)	18,955.9	20,525.6	23,024.3
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	80.0%	75.0%	70.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	58.9%	55.6%	62.3%
Засгийн газрын өр/ДНБ	69.0%	64.9%	75.5%

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын гадаад зээлийн өсөлт 2018 онд өмнөх оноос 22.3 хувиар, 2019 онд 14.3 хувиар, 2020 онд 28.9 хувиар тус тус өссөн байна. /График 3/


Нийт өсөлтийг 100.0 хувь гэж үзвэл ханшийн өөрчлөлтөөр 2018 онд 40.8, 2019 онд 25.0, 2020 онд 27.7 хувиар тус тус нэмэгдсэн байна. Энэ нь ам.доллартой харьцах төгрөгийн ханш 2018 онд 8.9, 2019 онд 3.5, 2020 онд 4.2 хувиар тус тус суларсан нь нөлөөлсөн байна.

График 2. Нийт өрийн бүтцэд эзлэх гадаад зээлийн эзлэх хувь



Эх сурвалж: Сангийн яам


График 3. Гадаад зээлийн үлдэгдлийн өсөлт



Монгол Улс 2018 онд 43.8 сая ам.доллар буюу 109.4 тэрбум, 2019 онд 38.1 сая ам.доллар буюу 103.5 тэрбум, 2020 онд 156.1 сая ам.доллар буюу 439.0 тэрбум төгрөг, нийт 238.0 сая ам.доллар буюу 651.9 тэрбум төгрөгийн тусламжийг 18 хандивлагч орон, олон улсын байгууллагаас авч ашигласан байна.

Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан нийт тусламжийн АХБ-аас 53.3 хувь буюу 347.2 тэрбум, БНХАУ-аас 18.9 хувь буюу 123.4 тэрбум, Япон улсаас 9.8 хувь буюу 63.7 тэрбум, АНУ-аас 7.5 хувь буюу 48.8 тэрбум, бусад хандивлагч орон, олон улсын байгууллагаас 10.5 хувь буюу 68.7 тэрбум төгрөгийг тус тус авч ашиглажээ. /График 4/

График 4. Гадаад тусламж, санхүүжүүлэгч байгууллагаар /2018-2020/



Эх сурвалж: Сангийн яам

БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛЭЭР САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙНА

Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг сонгох, үнэлэх, эрэмбэлэх аргачлалгүй бөгөөд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх бусад эх үүсвэрийн ашиглалт хангалтгүй байна

1.1. Өрийн удирдлагын тухай хуулийг 2015 онд баталснаар тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-т заасныг үндэслэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт⁴ тусгасан төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломж бүрдсэн боловч Монгол Улсын хөрөнгө оруулалтын 2013-2017, 2018-2021 оны хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээг сонгох, төсөвт өртгийг тооцох, эрэмбэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх холбогдох журам, аргачлалгүйгээр тойм төдий төлөвлөсөн байна.

1.2. Тухайлбал, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах зааврыг 2018 онд, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг боловсруулах аргачлал, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлалыг 2020 оны 6 дугаар сард тус тус баталж, улсын хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөрийг тус аргачлалын дагуу боловсруулж, баталсан байна. Мөн “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх хяналт тавих, үнэлэх журам”-ыг 2021 оны 1 дүгээр сард шинэчлэн баталсан байна.

1.3. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг УХОХ-т тусгахаар заасан боловч түүнээс доош өртөгтэй төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр хэрхэн санхүүжүүлэх талаар эрх зүйн зохицуулалтгүй байна.

1.4. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нийт санхүүжилтийн дүнгийн 2018 онд 23.7, 2019 онд 14.8, 2020 онд 20.4 хувийг тус тус гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2018 онд 87.6, 2019 онд 30.4, 2020 онд 55.2 хувийг тус тус санхүүжүүлсэн нь бусад эх үүсвэрийг ашиглах байдал хангалтгүй байна. /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл

Он	УХОХ-ийн төсөл, арга хэмжээний төлөвлөлт		Гадаад зээл, тусламжаар санхүүжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт		Хувь	УХОХ-ийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл		Гадаад зээл, тусламжаар санхүүжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэл		Хувь
	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжих дүн		Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжих дүн	Төсөл, арга хэмжээний тоо	Санхүүжих дүн	
2018	113	3,238.3	64	769.1	23.7	51	1,060.0	41	929.1	87.6
2019	149	9,726.5	72	1,439.5	14.8	90	3,760.0	52	1,144.1	30.4
2020	149	12,617.9	71	2,571.1	20.4	88	1,836.3	51	994.1	55.2

Эх сурвалж: Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, түүний тодотгол, Үндэсний хөгжлийн газар

1.5. Гадаад зээлийн хөрөнгөөр улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн дийлэнх хувийг⁵ санхүүжүүлж байгаа нь улсын урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд бусад эх үүсвэрийг ашиглах байдал хангалтгүй байгааг харуулж, өрийн дарамтад орох эрсдэлийг нэмэгдүүлэх тул цаашид улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх бусад эх үүсвэрийн ашиглалтыг нэмэгдүүлж, гадаад зээлийн өрийн дарамтын эрсдэлийг бууруулах нь зүйтэй байна.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нь Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагад нийцэхгүй байна

⁴ Төсвийн тухай хуулийн 28.1-т зааснаар эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулахаар заажээ.

⁵ сүүлийн 3 жилийн дунджаар 52.8 хувь

1.6. Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3⁶-т заасныг үндэслэн Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгасан нийт төсөл, арга хэмжээний 2018 онд 740.2 тэрбум төгрөгийн 55 төсөл, арга хэмжээ буюу 85.9, 2019 онд 1,009.8 тэрбум төгрөгийн 53 төсөл, арга хэмжээ буюу 73.6, 2020 онд 1,078.1 тэрбум төгрөгийн 55 төсөл, арга хэмжээ буюу 77.4 хувийг нь тус тус тухайн жилийн төсвийн тухай хуульд төлөвлөсөн байна. *Дүрслэл 1*

Дүрслэл 1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл /тэрбум төгрөг/

УХОХ-т	Тухайн оны төсвийн тухай хуульд	Гүйцэтгэл
<ul style="list-style-type: none"> • 2018 онд 64 төсөлд 769.1 тэрбум төгрөг, • 2019 онд 72 төсөлд 1,439.5 тэрбум төгрөг, • 2020 онд 71 төсөлд 2,571.1 тэрбум төгрөг. 	<ul style="list-style-type: none"> • 2018 онд 55 төсөлд 740.2 тэрбум төгрөг, • 2019 онд 53 төсөлд 1,009.8 тэрбум төгрөг, • 2020 онд 55 төсөлд 1,078.1 тэрбум төгрөг 	<ul style="list-style-type: none"> • 2018 онд 41 төсөлд 929.1 тэрбум төгрөг, • 2019 онд 52 төсөлд 1,144.1 тэрбум төгрөг, • 2020 онд 51 төсөлд 994.1 тэрбум төгрөг

Эх сурвалж: МУЗГ-ын 2018 оны 140 дүгээр тогтоол, 2019 оны 290 дүгээр тогтоол, Төсвийн тухай хууль, Сангийн яам

1.7. УХОХ-т тусгаагүй 2018 онд 92.2 тэрбум төгрөгийн 18, 2019 онд 90.5 тэрбум төгрөгийн 16, 2020 онд 376.6 тэрбум төгрөгийн 28 төсөл, арга хэмжээг тус тус жил бүрийн төсвийн тухай хуулиар хэрэгжүүлэхээр баталсан нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3-т заасан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан байх” шаардлагад нийцэхгүй байна.

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг батлан хэрэгжүүлсэн нь төсөл, арга хэмжээ удаашрах нөхцөлийг бүрдүүлж байна

1.8. Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4⁷, 18.5.7⁸ -д заасан шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлах ёстой боловч хуулийн шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг баталснаас шалтгаалан гадаад зээлийн хөрөнгийг ашиглаж эхлэхдээ тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээг хийж, баталгаажуулах зэргээр төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах нөхцөл бүрдсэн байна. Тухайлбал:

- Сангийн яам 2018-2023 онд АХБ-ны 25.0 сая ам.долларын зээлээр хэрэгжиж байгаа “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн саналыг боловсруулаагүй, төслийн хүрээнд баригдах шинэ дата төвийн барилгын зураг төсвийг боловсруулж, батлуулахгүйгээр зээлийн хэлэлцээрийг хийснээс шалтгаалан хэлэлцээр хийснээс хойш 702 өдөр буюу 1.9 жилийн дараа зураг төсвийг боловсруулж, Барилгын хөгжлийн төв 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зураг төсвийг баталсан байна. Тус зургийн ажлыг 40.0 мянган ам.долларын зээлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 2020 оны жилийн эцсийн байдлаар 18.2 мянган ам.доллар зарцуулсан байна.
- Сангийн яаманд 2016-2024 онд АХБ-ны 19.4 сая зээлжих тусгай эрх буюу 27.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн саналыг боловсруулаагүй, төслийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг, Боршоо боомтуудад баригдах барилга, хатуу хучилттай авто замын зураг төсвийг боловсруулж, батлуулалгүйгээр зээлийн хэлэлцээрийг байгуулснаас зураг төсөв боловсруулах зардалд зээлийн хөрөнгөөс нийт 1,140.9 мянган ам.долларыг зарцуулсан. Зураг төсвийг төсөл хэрэгжиж эхэлснээс хойш 3 жилийн дараа буюу 2019 онд боловсруулан батлуулж барилга, угсралтын ажлыг эхэлсэн байна. Зураг төсөв батлагдсаны дараа худалдан авах ажиллагаа удааширч, барилга угсралтын ажил гүйцэтгүүлэх гэрээг 2020 онд байгуулсан.
- Шадар сайдын харьяа МХЕГ, Мал эмнэлгийн ерөнхий газарт 2016-2022 онд АХБ-ны 15.0 сая ам.долларын зээлээр хэрэгжүүлж байгаа “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийг тооцоо, судалгаанд үндэслэн төлөвлөөгүйгээс төслийн зорилго, төсөвт өртөгт өөрчлөлт орж, төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна. Шалтгаан нь:

⁶ Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан байх;

⁷ Тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг хийж, баталгаажуулсан байх;

⁸ Тухайн төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж, баталгаажуулсан байх.

- Төслийн зураг төсвийг боловсруулах ажлын даалгаврыг зээлийн хэлэлцээр байгуулснаас хойш 3 жилийн дараа боловсруулж, тус төслийн хүрээнд баригдах барилгын зураг төсвийг 289.2 мянган ам.доллароор "Татах хүч" ХХК, "Хатанбаатар" ХХК-аар хийлгэн зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн. Төслийн хүрээнд 3 барилга барихаар тооцоолсон боловч хэрэгжилтийн явцад өөрчлөн 5 барилга барих гэрээг байгуулан ажиллаж байна. Төслийн зээлийн хэлэлцээрийг баталснаас хойш 232 хоногийн дараа буюу 2019 оны 8 дугаар сард 5 барилгын зураг төсвийг баталж дуусах үед 2 барилгын төсөв нь хуваарилагдсан санхүүжилтээс 3 дахин өндөр гарсан байна. Энэ нь төсөвт өртгийг 2.17 сая ам.доллароор өсгөж, зээлийн хэмжээг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.
- Мэргэжлийн хяналтын лабораторийн 3 барилга барихаас Дархан-Уул аймгийн барилга 23.0, Алтанбулаг боомтын барилга 10.0 хувийн тус тус хэрэгжилттэй, Сэлэнгэ аймгийн барилга баригдаж эхлээгүй байна. Тус 3 барилгын ажлыг "Грийнресурс" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус компани БШУЯ-ны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 2 барилга барих гэрээг давхар байгуулсан тул гэрээний хугацаанд барилга баригдахгүй байх эрсдэлтэй байна.
- Барилгын зураг төсөл боловсруулах, батлуулах, барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагаа удааширснаас барилга, байгууламжийг барих төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад ороогүйгээс шалтгаалан баригдсан барилга байгууламжид суурилуулахаар 2020 онд худалдан авсан 244.3 мянган ам.долларын, 519 ширхэг лабораторийн тавилга, тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.
- Зээлийн хэлэлцээрт төслийг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусахаар заасан боловч дээр дурдсан шалтгаанаар хугацааг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгасан бөгөөд 2020 оны байдлаар төсөл 61.0 хувийн хэрэгжилттэй, санхүүжилтийн гүйцэтгэл 3.05 сая ам.доллар буюу 23.0 хувьтай байна. Гэвч коронавируст (Ковид-19) цар тахлаас шалтгаалан дахин ажил удааширч сунгасан хугацаанд багтаан хэрэгжиж дуусахгүй байх эрсдэлтэй байна.
- МУЗГ нь БНЭУ-ын Экспорт-Импорт банктай 2012 оны 02 дугаар сарын 14-ний өдөр 20.0 сая ам.долларын "Атал Бихари Важпайн нэрэмжит мэдээллийн технологи, харилцаа холбоо, аутсорсингийн төв" байгуулах төслийн гэрээг байгуулсан боловч барилгын зураг төсвийг боловсруулж, батлуулаагүйгээс одоогийн байдлаар тус барилгын зураг төсвийг Барилгын хөгжлийн төв хянаж байна.
- Эрчим хүчний салбарын төслүүдийн ТЭЗҮ-ийг ихэвчлэн хандивлагч орон, санхүүжүүлэгч олон улсын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрээр хийсэн байна. Тухайлбал,
 - АХБ, Уур амьсгалын стратегийн сан, Япон улсын хамтарсан зээлийн сангийн эх үүсвэрээр баруун бүсэд нар, салхины эрчим хүч ашиглан тухайн орон нутгийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах эх үүсвэрүүдийг шинээр байгуулах хэрэгжиж буй "Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл"-ийн ТЭЗҮ болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг АХБ-ны техник туслалцааны төслөөр хийсэн.
 - "ДЦС-4" ТӨХК-ийн уурын турбины тохируулгын систем ба технологийн удирдлагыг цахилгаан гидравлик болгон шинэчлэх, зуухнуудад тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилготой Япон улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих "Улаанбаатар хотын дөрөвдүгээр цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх MON-P10" төслийн ТЭЗҮ-ийг ЯОУХАА-ын санхүүжилтээр тус улсын J-Power компани 2012 онд хийж гүйцэтгэсэн.
 - "ЦДҮС" ТӨХК-ийн төвийн эрчим хүчний системийн гол зангилаа станцуудын ашиглалтын хугацаа хэтэрсэн, технологийн хувьд хоцрогдсон тоног төхөөрөмжийг шинэчлэх ХБНГУ-ын СБХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж "Төвийн бүсийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл"-ийн ТЭЗҮ-ийг 2016 онд Герман улсын Lammeuer компани боловсруулсан.
 - БНСУ-ын санхүүжилтээр "10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ барих" төслийн ТЭЗҮ-ийг тус улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Кэй-Ди-Эйч-И /KDHE/ компани 2018 онд боловсруулсан.
 - ХБНГУ-ын СБХБ-ны санхүүжилтээр хэрэгжсэн "Дарханы ДЦС-ын турбины шинэчлэл" төслийн ТЭЗҮ-г тус банкны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2005 оны 5 дугаар сард Герман улсын Fichther компаниар хийсэн байна.
- "Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замыг барьж ашиглалтад оруулах зорилтын хүрээнд АХБ болон ЕСБХБ-ны зээлийн хөрөнгөөр нийт 188.8 сая ам.долларын гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч авто замын зураг төсвийг олон удаа өөрчилсөн, хучилтын зузааны хэмжээг 5 см /АХБ/, 10 см-ээр /ЕСБХБ/ зөрүүтэй баталж барилга угсралтын ажлыг эхлүүлсэн, зарим гүйцэтгэгчийн гэрээ цуцлагдсан, төслийн хэрэгжилт удааширсан байна.

1.9. Засгийн газрын шинээр авах зээл нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3, 18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар Сангийн яам санал, дүгнэлт гаргахаар тус хуулийн 18 дугаар зүйлийн 18.6⁹-д заасан боловч хэрэгжүүлээгүй байна.

1.10. Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төслийн баримт бичиг ямар түвшинд боловсруулагдсан байх, ТЭЗҮ, төслийн баримт бичгийн үнэлгээг аль үе шатанд хийх зэрэг аргачлалыг хууль, журамд тодорхой тусгаагүй, эрх зүйн зохицуулалтгүй байна.

Тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан санхүүжилтийг хэтрүүлэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна

1.11. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас 2018 онд 83 төсөл, арга хэмжээнд 835.6 тэрбум, 2019 онд 76 төсөл, арга хэмжээнд 1,096.3 тэрбум, 2020 онд 94 төсөл, арга хэмжээнд 1,472.9 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ. /Хүснэгт 3/, /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/

Хүснэгт 3. Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Он	Төлөвлөлт		Гүйцэтгэл		Гүйцэтгэлийн хувь
	Гэрээний тоо	Санхүүжих дүн	Гэрээний тоо	Санхүүжих дүн	
2018	83	835.9	62	1,007.1	120.5
2019	76	1,096.3	79	1,230.4	112.2
2020	94	1,472.9	91	1,390.4	94.4

Эх сурвалж: Сангийн яам

1.12. Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна” гэж заасныг үндэслэн төслийн нэгжүүд дараа оны төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдөр Сангийн яаманд хүргүүлж, төсвийг 11 дүгээр сард баталдаг.

1.13. Төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу тухайн жилийн өрийн хязгаарт нийцүүлэн төлөвлөх шаардлагатай тул зээлийн ашиглалтыг багаар төлөвлөдөг, тайлант хугацааны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг гаргах үед валютын ханшийн өөрчлөлт ордог, төлбөрийг хугацаанд нь гаргахгүй бол алданги тооцдог, санхүүжүүлэгч байгууллагууд 1-2 сарын хугацаанд гүйцэтгэлийг хянадаг, зээл олгогч тал төслийг шууд санхүүжүүлсэн тохиолдолд зээлийн ашиглалтын дүн өсдөг зэргээр баталсан төсөв хэтрэх нөхцөл бүрддэг байна.

1.14. Дээрх байдлаас шалтгаалж тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан санхүүжилтийг 2018 онд 171.2 тэрбум төгрөг буюу 20.5, 2019 онд 134.1 тэрбум төгрөг буюу 12.2 хувиар тус тус хэтрүүлж, харин 2020 онд баталсан санхүүжилт хэтрээгүй байна. Энэ нь 2019 оноос эхэлж жил бүрийн Төсвийн тухай хуульд нийт төсөл, арга хэмжээний санхүүжилтийн багцыг Сангийн сайдад шилжүүлж, нэгдсэн удирдлагаар хангасантай холбоотой байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү/

1.15. Төсөл, арга хэмжээ богино хугацаанд хэрэгжиж, урт хугацаанд үр ашиг гардаг боловч төсөл, арга хэмжээг тооцоо, судалгаанд үндэслэн хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлэх, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай нь уялдуулан төлөвлөх байдал хангалтгүй байна.

1.16. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн хязгаарыг 2020-2022 онд 70.0 хувь, 2023 онд 65.0 хувиас хэтрүүлэхгүй байхаар туссан тул гадаад зээлийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломж багасах эрсдэлтэй байна.


Засгийн газрын гадаад зээлийн тодорхой бодлогогүйгээс гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний зорилт үр дүнгүй болох эрсдэлтэй байна

⁹ Засгийн газрын шинээр хийх зээллэг нь энэ хуулийн 18.5.3, 18.5.4, 18.5.7-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санал, дүгнэлт гаргана.

1.17. Төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтын сүүлийн таван жилийн байдлыг салбараар нь авч үзвэл дэд бүтцийн салбарт 60.0 хувь, нийгмийн салбарт 19.9 хувь, төрийн удирдлага болон санхүүгийн салбарт 10.1 хувь, харин үйлдвэрлэлийн салбарт гадаад зээлийн эзлэх хувь хамгийн бага буюу 5.7 хувийг тус тус ашигласан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/

1.18. Нийгмийн болон төрийн удирдлага, санхүүгийн салбарын зээлийн хөрөнгийн ашиглалт өсөж, дэд бүтэц болон үйлдвэрлэлийн салбарт буурсан үзүүлэлттэй байна. /График 5/

График 5. Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт, салбараар




1.19. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль /хуучин нэрээр/-ийн 6 дугаар зүйлд заасан урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”¹⁰-д салбар тус бүрд баримтлах бодлогын зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Эх сурвалж: Сангийн яам

1.20. Тогтвортой хөгжлийн 14 зорилтоос 10 зорилтын хүрээнд хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч ашигласан байна. /График 6/

График 6. Тогтвортой хөгжлийн зорилтод чиглэсэн гадаад зээлийн санхүүжилтийн хувь



Эх сурвалж: Аудитын тооцоолол

1.21. Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т “Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох” гэж заасан боловч өнөөдрийг хүртэл УИХ-аас гадаад зээлийн бодлогыг батлаагүй байгаа нь гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, зорилт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

1.22. Монгол Улс гол хандивлагч орон, олон улсын байгууллагатай дунд хугацааны стратегийн түншлэлийн гэрээ байгуулснаар зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх салбар, чиглэлийг тодорхойлдог байна. Тухайлбал:

- Дэлхийн банк, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын хөгжлийн ассоциаци, Олон улсын санхүүгийн корпорац болон Олон талт хөрөнгө оруулалтын баталгааны агентлагийн Монгол Улсад зориулсан 2013-2017 оны санхүүгийн жилийн түншлэлийн стратегийн баримт бичигт:
 - Уул, уурхайн эдийн засгийг тогтвортой, ил тодоор удирдах талаар Монгол Улсыг чадавжуулах;

¹⁰ УИХ-аас 2020 онд “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг баталснаар УИХ-аас 2016 онд баталсан “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичиг хүчингүй болсон ч “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод гол зорилтууд тусгагдсан байна.

- Хот болон хөдөөд эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой, олон тулгуурт суурь бий болгох;
- Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг илүү хүргэх, нийгмийн хамгааллын системийг сайжруулах, гамшигийн эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох замаар эмзэг байдал, өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлын асуудлыг шийдвэрлэх.
- Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Монгол Улсад баримтлах стратеги 2017-д:
 - Олборлох бус салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, санхүүгийн эх үүсвэр олох гарцыг хялбаршуулах замаар Монголын тэсвэрлэх чадварыг сайжруулах;
 - Тогтвортой ажиллагааг бэхжүүлэх, үнэ өртөг нэмэгдүүлэх ажлыг дээд хэмжээнд хүргэх зорилгоор сайн засаглалтай уул уурхайн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх;
 - Үр ашгийг нэмэгдүүлэх, арилжааны хэлбэрт оруулах, “ногоон” шийдэл олох замаар дэд бүтцийн үйлчилгээний салбарын чанар, тогтвортой байдлыг сайжруулах.
- АХБ-ны Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги 2017-2020-д:
 - Нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах;
 - Эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэх;
 - Байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих.

1.23. Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хандивлагч орон, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагын бодлоготой өөрийн орны бодлогыг уялдуулан идэвхтэй хамтран ажиллах талаар стратеги түншлэлийн хэлэлцээрийг сайжруулах, үйлдвэрлэлийн салбарын зээлийн ашиглалтыг нэмэгдүүлж, үйлдвэрийн орлого, ашгаар эдийн засагт дэмжлэг болох зэргээр зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

1.24. Гадаад зээлийн хөрөнгөөр 1995-2020 нийт 2482.3 км авто зам, гүүрний барилга байгууламж ашиглалтад оруулж, эрчим хүчний томоохон станцуудад засвар, шинэчлэлт хийснээр 70 мВт суурилагдсан хүчин чадал нэмэгдэж, 57 дэд станц шинээр барьж, 1,446.5 км урт цахилгааны шугам сүлжээг ашиглалтад оруулжээ.

1.25. Аудитад хамрагдсан зарим ТЕЗ нарын хэрэгжүүлж байгаа дараах төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

БХБЯ:

- ЗТБХБЯ /хуучнаар/ БНХАУ-ын “Бээжин констракшн инженеринг групп” ХХК-тай 2010 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр Улаанбаатар хотын VII хороолол, Монголын үндэсний олон нийтийн радиол телевиз орчмын орон сууцны хорооллуудын инженерийн шугам сүлжээ барих ажлын 47.05 сая ам.долларын гэрээг байгуулжээ. Үүний 40.0 сая ам.долларыг БНХАУ-ын зээлээр, 7.05 сая ам.долларыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна. Дээрх гэрээний дагуу дараах 3 багц ажлыг хийж гүйцэтгэхээр тусгасан. Төслийн хүрээнд нийт 54,914.4 сая төгрөгийн өртөгтэй цахилгааны дэд станцууд, цахилгаан хангамжийн дэд өртөө, хуваарилах байгууламж, кабель шугам сүлжээ мөн ус, дулаан дамжуулах төв, дулаан, цэвэр бохир усны шугам сүлжээний барилга байгууламжийг 2016-2019 онд барьж ашиглалтад оруулжээ. 2020 оны байдлаар төслийн хүрээнд бий болсон инженерийн барилга байгууламжийг “ЦДҮС” ТӨХК, “УБЦТС” ТӨХК, Ус сувгийн удирдах газар, “Улаанбаатар дулаан сүлжээ” ТӨХК, ОСНААУГ, “Габот” ХХК зэрэг байгууллагууд ашиглаж байгаа боловч данс бүртгэлдээ тусгаагүй байна.
- Засгийн газар АХБ хооронд 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийн зээлийн гэрээг 20.6 сая ам.долларын дүнтэй байгуулсан байна. БХБЯ “Пфайфер болон Эмит” түншлэлтэй 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр гэрээ байгуулж, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад оруулахаар тусгажээ. Төслийн нийт төсөвт өртөг 18.1 сая ам.доллар үүнээс 12.5 сая ам.долларын санхүүжилт олгосон. Төслийн барилга угсралтын ажлын гэрээний дүн 16.2 сая ам.доллар, гүйцэтгэгчид олгосон санхүүжилт 10.9 сая ам.доллар буюу 67.0 хувьтай байна. Нийт 3 бүрэлдэхүүний хүрээнд 82 төрлийн барилга байгууламж барихаас 2020 оны байдлаар 10 барилга байгууламжийн зураг, төсөвт өөрчлөлт оруулж, барилгын ажил эхлээгүй 9 барилга байгууламж байна. Төслийн хүрээнд 2020 онд 14 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувь хэрэгжсэн 8, 70 хувьтай 2, хэрэгжээгүй 3 арга хэмжээ тус тус байна. Төслийн үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөний биелэлт 69.2 хувьтай байна. Ерөнхий гүйцэтгэгч Пфайфер болон Эмит түншлэл нь төслийн 1 болон 2 дугаар бүрэлдэхүүн хэсэгт туслан гүйцэтгэгч компаниуд шалгаруулж ажилласан боловч зарим гүйцэтгэгчтэй гэрээ цуцалсан, ажлын гүйцэтгэлийн санхүүжилт олгоогүй удсан, шинээр туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан нь төслийг хугацаанд нь хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн байна. Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлын ерөнхий гүйцэтгэгч Пфайфер болон Эмит түншлэл барилгын ажлыг батлагдсан график төлөвлөгөөний дагуу

гүйцэтгээгүй, гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй байгаад дүгнэлт хийн гэрээнд заасны дагуу алданги болон хариуцлага тооцох ажлыг зохион байгуулаагүй байна.

БШУЯ:

- АХБ-ны 50.0 сая ам.долларын зээлээр хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн 5 бүрэлдэхүүн хэсгийн нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Улаанбаатар хот болон орон нутаг дахь цэцэрлэг, сургуулийн элсэлтийн ачаалал ба хүчин чадлын зөрүүг багасгаж, хичээлийн байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 32 сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барихаар төлөвлөсөн. Үүнээс 1 цэцэрлэгийн барилга барих газрын асуудал шийдэгдээгүй байна. Төслийн үйл ажиллагааны хүрээнд 33,903.9 сая төгрөгийн дүнтэй 88 гэрээ байгуулсан байна. Тус зээл нь Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.4 дахь заалтыг баримтлаагүйгээс зураг төсвийг боловсруулах тендер зарлах, зураг төсвийг баталгаажуулах ажилд хугацаа ихээр алдаж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах төслийн хугацааг 2 жил 6 сараар сунгах нөхцөлийг бий болгосон байна. Ингэснээр төслийн үр өгөөж буурч, төслийн нэгжийн зардал өссөнөөс гадна төслийн нэгжийн байрлаж буй байрны 2 жил 6 сарын түрээсийн зардал 153.3 сая төгрөгийг арвиан хэмнэх боломжийг алдаж байна. Төслийн хэрэгжих хугацаа сунжирснаар 2020 онд барилгын материалын үнэ өсөж, төслийн хүрээнд баригдах 31 барилгын санхүүжилт хүрэлцэхгүйд хүрч, баталсан зээлийн хөрөнгөөр нэгдүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 23 барилгын ажлыг гүйцэтгэх боломжтой бол үлдсэн 8 барилгын ажлыг нэмэлт санхүүжилт шийдвэрлэсэн тохиолдолд хэрэгжүүлэхээр болсон байна.

ЭМЯ:

- “Монгол Улсад COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл”-ийн хэрэгжилтийг шалгахад “Шинэ коронавирусын халдварын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд Нийслэлийн эх, хүүхдийн эмнэлэгт шаардлагатай компьютер, тоног төхөөрөмж нийлүүлэх” худалдан авах ажиллагааг 2020 оны 12 дугаар сард зохион байгуулж, 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр шалгарсан компанид гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсний дараа 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Ай Ти Зон” ХХК-ийн “Төлбөрийн нөхцөлд өөрчлөлт оруулах тухай” хүсэлтийг үндэслэн Захиалагч тендерийн бичиг баримтад заасан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийн төлбөрийн заалтыг зөрчин гэрээний тусгай нөхцөлийг өөрчилж, барааг нийлүүлээгүй байхад гэрээний үнийн дүнгийн 80.0 хувь болох 847.4 сая төгрөгийг олгосон байна.

1.26. Зээлийн хэлэлцээрт эх үүсвэрийн хувьд харьцангуй хөнгөлөлтийн түвшин өндөр байдаг ч төслийн гүйцэтгэгчээр санхүүжүүлэгч болон хүлээн зөвшөөрсөн орны хуулийн этгээдийг сонгох, бараа, ажил, үйлчилгээ, тоног төхөөрөмжийг бүх төрлийн татвараас чөлөөлөх, зээлийн санхүүжилтийн 50.0-95.0 хувь нь зээлдүүлэгч талд оногдох буюу дийлэнх хэсэг нь зээлдүүлэгч орны аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны зардал, худалдан авсан бараа, материалын үнэ, тээвэрлэлт, суурилуулалтын зардалд шингэж байна. Тухайлбал:

- БНХАУ-ын Засгийн газраас МУЗГ-т олгох 1.0 тэрбум ам.долларын “хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээр”-т төсөл тус бүрийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын аж ахуй нэгж ажиллах бөгөөд зээлдүүлэгчийн баталсан зохих гэрээлэгчдийн жагсаалтаас сонгох, зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэхэд зориулсан бараа, ажил үйлчилгээг гааль, НӨАТ болон Монгол Улсын ТБОНӨХБАУХАТХ-ийн нөхцөл шаардлагаас чөлөөлөх, зураг төсөл, барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийн гэрээний үнийн дүнгийн 50.0 хувиас багагүй нь, тоног төхөөрөмж худалдан авах төслийн хувьд шаардлага хангасан төслийн гэрээ бүрийн 65.0 хувиас багагүй нь БНХАУ-ын талд оногдохоор заасан байна.
- БНСУ-ын Засгийн газраас 10 аймагт дулааны станц барих төслийн зээлийн хэлэлцээрт зөвлөхүүд болон нийлүүлэгчид нь БНСУ-ын харьяат эсхүл харьяалах бүртгэл хийлгэсэн хуулийн этгээд байх, аливаа үйлчилгээнд ногдох татвар, хураамж болон шимтгэлийг Зээлдэгч хариуцах буюу чөлөөлөх, сонгон шалгаруулалтыг санхүүжүүлэгч банкны журмыг баримтлах, тухайн банктай урьдчилан хэлэлцэн, зөвшилцсөний үндсэн дээр зээлийн хөрөнгөөр эрх бүхий бус орноос худалдан авах бараа, үйлчилгээний өртөг нь зээлийн хөрөнгийн 35.0 хувиас ихгүй байхаар заасан байна.
- АХБ-ны худалдан авах ажиллагааны журамд тусгай сангийн хөрөнгөөс олгох зээл, буцалтгүй тусламжийг зөвхөн түүний санхүүжилтийн эх үүсвэрийг гаргаж буй хөгжингүй орон эсвэл хөгжиж буй гишүүн орон үйлдвэрлэсэн ба түүнээс нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар заасан байна.
- Германы СБХБ-ны санхүүжилтийн зээлийн хэлэлцээрт хүлээн авагч нь төсөл хэрэгжих хугацаанд зээлийн санхүүжилтээр авч буй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг санхүүжүүлэгч байгууллагын худалдан авах ажиллагааны журам, үйл ажиллагааны гарын авлагад тусгасан шаардлагад нийцүүлэн үйл ажиллагаа ажиллах хүч, нөөц бололцоогоор хангахаар заасан байна.

- БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй Эрдэнэтийн ДЦС-ын 35 мВт-ын өргөтгөлийн тусгайлсан гэрээнд төслийн нийт өртөг 51.8 сая ам.доллар бөгөөд үүний 49.2 сая ам.доллар буюу 95.0 хувь нь БНХАУ-аас худалдан авсан тоног төхөөрөмж түүний тээвэрлэлтийн зардал болон инженер техникийн ажилчдын зардалд зарцуулагдаж, 2.0 сая ам.доллар нь уг барилгын барилга угсралтын материал /бетон, арматур, бусад материал/ болон техникийн хяналтын зардалд буюу дотоодын худалдан авалтад зарцуулагдсан байна.

1.27. Иймд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг үйлдвэрлэлийн салбарт чиглүүлж дэмжсэнээр цаашид хэрэглэгчээс үйлдвэрлэгч орон болох, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг дотоодоос хийх, Монгол Улсын эдийн засагт үр ашигтай байх, импортыг орлох зэрэг эерэг үр нөлөөтэй бөгөөд гадаад зээлийн хөрөнгийг дотоодын зах зээлд илүү шингээх боломжтой байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна

1.28. Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 4.1.8-д төслийг гэрээ, хэлэлцээр болон батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу тогтоосон хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор өдөр тутмын үйл ажиллагаагаар хангах үүрэг бүхий Төсвийн тухай хуулийн 17.1¹¹-д заасан орон тооны нэгжийг ТХН гэж тодорхойлжээ. Тус журмын 16.1¹²-т зааснаар гэрээ хэлэлцээрт төсөл хэрэгжүүлэгч нэгжтэй байхаар заасан тохиолдолд ТХН байгуулахаар заасан байна.

1.29. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага ТХН-ийг бодлого, чиглэл, удирдлага, зохион байгуулалтаар хангах, төслийн ажилтныг сонгон шалгаруулах, ажлын даалгавар боловсруулахад хугацаа алдсанаас төслийг гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд хэрэгжүүлж дуусахад сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал:

- Шадар сайдын харьяа МХЕГ, Мал эмнэлгийн ерөнхий газарт 2016-2022 онд АХБ-ны 15.0 сая ам.долларын зээлээр хэрэгжиж байгаа “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийн ТУХ-г зээлийн хэлэлцээр байгуулснаас хойш 245 хоногийн дараа, төслийн нэгжийн үйл ажиллагааг 325 хоногийн дараа зохион байгуулсан, барилгын хамгийн сүүлийн зураг, төсөв 232 хоногийн дараа батлагдсан, төслийн нэгжийн зарим ажилтнуудыг 1.4 жил, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг 1 жилийн хугацаанд сонгон шалгаруулж, төслийн зээлийн хэлэлцээр батлагдсанаас хойш 232 хоногийн дараа 5 барилгын зураг төсвийг батлуулсан зэргээр хугацаа алдаж, анхны ажил гүйцэтгэх гэрээг зээлийн хэлэлцээр байгуулснаас хойш 2 жилийн дараа байгуулсан;
- АХБ-ны “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төсөл”-ийн хүрээнд баригдах шинэ дата төвийн барилгын зураг, төсвийг зээлийн хэлэлцээр байгуулснаас 702 өдрийн дараа буюу 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр батлуулсан байна.
- Төсөл хэрэгжүүлэгч ОБЕГ-аас Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 15 дахь заалтыг тус газарт хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд ТУХ-г байгуулаагүй. Мөн журмын 6 дугаар зүйлд Эрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагад нийцсэн төслийн саналыг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлсэн баримт бичиг баримтаар нотлогдохгүй, мөн журмын 8.1 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй дараах төсөл, арга хэмжээнүүд байна. Үүнд:
 - ОБЕГ-т гал унтраах машин тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл 13.1 сая еврогийн гэрээний дүнтэй, 2019-2021 онд хэрэгжиж дуусах төсөл;
 - Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн эмнэлэг төсөл 6.7 сая еврогийн гэрээний дүнтэй, 2018 онд хэрэгжиж дууссан төсөл;
 - Онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл 58.0 сая евро гэрээний дүнтэй 2021 онд хэрэгжиж дуусах төсөл.

¹¹ Олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад олгож байгаа зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байна.

¹² Гэрээ, хэлэлцээрт ТХН байгуулахаар тусгайлан заасан бол төсөл хэрэгжүүлэгч байгууллагын зүгээс тухайн ТХН-ийн бүтэц, орон тооны саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлнэ.

1.30. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.1.26¹³ дахь заалтыг хэрэгжүүлээгүй буюу 2018-2020 онд хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний 88.9 хувь нь төсөл хэрэгжиж дууссаны дараа төслийн үр нөлөөний үнэлгээг хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээгүй, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулаагүй байна. Тухайлбал:

БХБЯ:

- Орон сууцны хороолол, дэд бүтцийн төсөл;
- Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл;

БШУЯ:

- Дээд боловсролын шинэчлэл төсөл;
- Шинэ зууны боловсрол төсөл;

ЗТХЯ:

- Улаанбаатар-Хөшигтийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих төсөл;
- Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км автозам барих төсөл;
- Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км автозам барих төсөл;
- Бүс нутгийн логистикийг хөгжүүлэх төсөл;
- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хөтөлбөр /Төсөл 1/;
- Уньт-Тариалан-Мөрөн автозамын төсөл;

НЗДТГ:

- Улаанбаатар цэвэр агаар төсөл;
- Замын цагдаагийн газрын дэргэдэх уулзварт гүүрэн гарц байгуулах төсөл;
- Олон улсын автобусны паркийн шинэчлэл төсөл;
- Улаанбаатар хотын нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл II;

ОБЕГ:

- Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн эмнэлэг барих төсөл;
- Гал түймэртэй тэмцэх техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл;

Сангийн яам:

- Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл;

ХХААХҮЯ:

- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл;

ЭМЯ:

- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг төсөл;
- Цахим эрүүл мэнд төсөл;
- Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн хүлээн авах төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл;

ЭХЯ:

- Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл.

1.31. ТХН-ийн үйл ажиллагааг эхлэхээс дуусах хүртэлх хугацааны ажлын хариуцлага, чанар байдлыг алдагдуулахгүй байх хяналт, зохицуулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа гарах үр нөлөөг үе шаттай үнэлэх зэрэг харилцааг журамд тусгах шаардлагатай байна.


¹³ төсөл хэрэгжиж дууссаны дараа төслийн үр нөлөөний үнэлгээг хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулах.

Дотоодод дамжуулсан зээлийн 47.0 хувь нь эргэн төлөгдөөгүй байна

1.32. Сангийн яам гадаадын зээлийг дотоодод дамжуулан зээлдүүлэх хууль, эрх зүйн зохицуулалтыг өнөөгийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн шинэчлээгүй, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын зарим заалтыг хэрэгжүүлээгүй, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Тухайлбал, Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.9¹⁴, 9.1.10¹⁵, 18.5.5¹⁶-д Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийж, зөвхөн эргэн төлөгдөх чадвартай төсөл, арга хэмжээнд зээл олгохоор зохицуулсан боловч “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-д эрсдэлийн үнэлгээг хийх аргачлалыг боловсруулан гаргаагүй, эрсдэлийг хэрхэн үнэлэх талаар тодорхой зохицуулалт байхгүй байна.

1.33. УАГ-аас 2017 онд “Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар Сангийн сайдад Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ыг 2015 онд баталсан Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах зөвлөмж хүргүүлсний дагуу журмыг шинэчлэн боловсруулж, 2021 оны 7 дугаар сард баталсан байна.

График 7. Дамжуулан зээлийн эргэн төлөлт /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

1.34. Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлээс 2018 онд 48.3 тэрбум, 2019 онд 50.4 тэрбум, 2020 онд 182.8 тэрбум төгрөгийг тус тус эргэн төлсөн бөгөөд санхүү, эдийн засаг, эрчим хүчний салбарын зээлийн эргэн төлөлт өндөр хувьтай байна. /График 9/, /Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс үзнэ үү/

1.35. Өрийн удирдлагын тухай хуулийн 30.6-д “Дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээний нөхцөлийг Засгийн газрын тухайн зээллэгийн нөхцөлтэй уялдуулан тодорхойлох бөгөөд төсөвт аливаа нэмэлт төлбөрийн дарамт учруулахгүй байх зарчмыг баримтална”, Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын 3.5, 3.6-д “Сангийн яамнаас зээлдэгчид дамжуулан зээлийг олгохдоо гадаадын зээлийг анх авсан валютаар тооцож олгох, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх валютын ханшийн зөрүүг зээлдэгч хариуцна” гэж заасныг тус тус зөрчин дотоодод төгрөгөөр олгосон нийт 577.0 тэрбум төгрөгийн 118 дамжуулан зээлийн хүүгийн төлбөрт 2020 оны жилийн эцсийн байдлаар 50.8 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн байна.

1.36. Эрчим хүчний салбарт олгосон 204.5 тэрбум төгрөгийн 27 зээлийг “Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хамтарсан 276/300 дугаар тушаалаар төгрөгт тооцож, шилжүүлсэн байна.

1.37. Дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагын тайланд эргэн төлөөгүй зээл 2018-2020 оны дунджаар нийт зээлийн 47.0 хувийг эзэлж, зээлийн үлдэгдэл 2016 онд 790.9 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 77.2 хувиар өсөж, жилийн эцэст нийт 73 зээлийн 1,402.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү./ Тухайлбал:

- БНХАУ-ын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл”-ийн хүрээнд БХБЯ-аас 2011-2014 онд “Цагаан хуаран” ХХК, “Бэрэн групп” ХХК-

¹⁴ Засгийн газрын дамжуулан зээлдүүлэх болон өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах


¹⁵ Эрсдэлийн үнэлгээгээр тухайн зээллэгийн хөрөнгийг хугацаандаа бүрэн төлөх нь батлагдсан төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр Засгийн газрыг төлөөлж дамжуулан зээлдүүлэх

¹⁶ Гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлж байгаа тохиолдолд тухайн төсөл, арга хэмжээ эдийн засгийн үр ашигтай, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон байх

тай 70.5 сая ам.долларын¹⁷ дүнтэй давхар дамжуулан зээлийн гэрээ байгуулан, тус компаниуд нийт 2592 айлын 36 орон сууцны барилга бүхий “Хангай хотхон”, “Цагаан хуаран” орон сууцны хотхоныг барьж ашиглалтад оруулжээ. Гэвч тус компаниуд нь эргэн төлөлт хийж эхлээгүй байгаагаас “Бэрэн групп” ХХК-ийн үндсэн зээл 50.9 сая ам.доллар, хүүгийн төлбөр 29.9 сая ам.доллар, “Цагаан хуаран” ХХК-ийн үндсэн зээл 19.6 сая ам.доллар, хүүгийн төлбөр 11.5 сая ам.долларын үлдэгдэлтэй байна. БХБЯ-аас Эрүүгийн цагдаагийн албаны эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт 2020 оны 3 дугаар сарын 04-ний өдөр гомдол, ХУД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдөр нэхэмжлэл гаргасан байна. Тус асуудлыг УАГ-аас удаа дараагийн хийсэн аудитаар илрүүлж, Сангийн сайдад зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлэх, хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулахаар хүсэлт гаргаж байсан боловч одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байна.

- Монгол Улс, БНХАУ-ын Экспорт-Импорт банкны хооронд 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдөр байгуулсан хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлсэн “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн парк шинэчлэл” төслийн хүрээнд “Монголын төмөр зам” ТӨХК-д 2020 онд 28.6 сая ам.долларын дамжуулан зээлийг олгожээ. Тус дамжуулан зээлийн хөрөнгөөр Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлд 267 км төмөр зам баригдаж, ашиглалтад орсны дараа ашиглах төмөр замын арчилгаа, зам засварын 28.6 сая ам.долларын өртөгтэй 65 ширхэг тоног төхөөрөмжийг худалдан авсан боловч тоног төхөөрөмжийг ашиглах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоогүй, төмөр замын бүтээн байгуулалтын ажил зогссон тул 2010 оноос хойш ашиглалтгүй, үр ашиггүй хөрөнгө болсон байна.
- Засгийн газраас Эгийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ-г боловсруулах зорилгоор 1991-1993 онд АХБ-ны 3.8 сая ам.долларын зээлийг Эрчим хүчний газарт дамжуулан зээлдүүлсэн байна. Гэвч Эгийн голын цахилгаан станц төсөл хэрэгжээгүйгээс 2020 оны байдлаар зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болох 10.5 тэрбум төгрөг үр ашиггүй болж, эргэн төлөгдөөгүй байна.

График 8. Эргэн төлөлтгүй дамжуулан зээлийн үлдэгдэл



Эх сурвалж: Сангийн яам

1.38. Сангийн яам дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн гэрээ байгуулахдаа Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын 4.2, 4.9, 4.10, 4.11 -т заасныг мөрдөөгүй, зээлийн барьцаа, батлан даалтын гэрээ байгуулаагүй, зарим зээл ямар нөхцөл, шалтгаанаар эргэн төлөхгүй байгааг тодруулаагүй, ямар шалтгаанаар төлөх найдваргүй болсон нь тодорхойгүй, эргэн төлөх чадваргүй төсөлд зээл олгосон, зээлдэгч тогтоосон хугацаа, хуваарийн дагуу зээлийг төлөөгүй, насжилт өндөртэй зээлийг барагдуулах ажлыг зохион байгуулаагүй, зээлийн эргэн

¹⁷ Одоогийн ханшаар 273.6 тэрбум төгрөг.

төлөлтөд тавих хяналт сул байгаагаас зээлийн үлдэгдэл өсөж, улсын төсөвт дарамт учруулж байна .

1.39. Дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагыг 2020 оны жилийн эцэст эргэн төлөлт хийдэггүй нийт 73 зээлийн 1.4 их наяд төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнаж, 54 гадаад зээлийн хүүгийн болон үндсэн төлбөрт улсын төсвөөс 1.5 их наяд төгрөгийг төлжээ. Үүнийг Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжих хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 1347 төсөл, арга хэмжээний 1.3 их наяд төгрөгтэй харьцуулахад 1.1 дахин их байгаа нь алдагдсан боломж байгааг харуулж байна.

1.40. Иймд дотоодод дамжуулан зээлсэн эргэн төлөлтгүй зээл тус бүрийн төлөгдөхгүй байгаа учир шалтгааныг тодруулж, эзэн холбогдогч нь тодорхой зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, улсын төсөвт үзүүлэх дарамтыг бууруулах нь зүйтэй байна.

Засгийн газрын гадаад зээлийн 44.1 хувийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулж байна

1.41. Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасныг үндэслэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар 2018 онд 474.8 тэрбум, 2019 онд 408.1 тэрбум, 2020 онд 1,978.0 тэрбум, нийт 2,860.9 тэрбум төгрөгийн гадаад зээлийг хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан байна.

1.42. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар авсан гадаад зээлийн үлдэгдэл 2018 онд 2,617.7 тэрбум, 2019 онд 3,088.1 тэрбум, 2020 онд 5,223.5 тэрбум төгрөг болсон бөгөөд энэ нь 2018-2020 онд авсан нийт гадаад зээлийн 44.1 хувийг эзэлж байна. /Хүснэгт 4/

Хүснэгт 4. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зээлийн хөдөлгөөн /тэрбум төгрөг/

Он	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл
2018	1,919.2	474.8	3.5	227.2	2,617.7
2019	2,617.7	408.1	35.7	98.0	3,088.1
2020	3,088.1	1,978.0	67.6	225.0	5,223.5

Эх сурвалж: Сангийн яам

1.43. Монгол Улсын 2018, 2019, 2020 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийг 2,224.5-5,252.7 тэрбум төгрөгийн алдагдалтай баталж, гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцэл 2018 онд 27.9 тэрбум төгрөгийн ашигтай, 2019 онд 756.2 тэрбум, 2020 онд 4,440.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь төлөвлөсөн дүнгээс 2018 онд 2,658.2 тэрбум, 2019 онд 1,468.4 тэрбум, 2020 онд 812.3 тэрбум төгрөгөөр тус тус бага гарч шинээр үүсгэх өрийн хэрэгцээг багасгасан байна. /Хүснэгт 5/

Хүснэгт 5. Төсвийн алдагдал, төсвийн алдагдлыг нөхөх зээлийн харьцуулалт /тэрбум төгрөг/

Он	Төсвийн тухай хуулиар баталсан		Гүйцэтгэл		Төлөвлөлт, гүйцэтгэлийн зөрүү	
	Төсвийн алдагдал	Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр - гадаад зээл	Төсвийн алдагдал	Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр - гадаад зээл	Төсвийн алдагдал	Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр - гадаад зээл
2018	(2,630.3)	1,534.4	27.9	474.8	(2,658.2)	1,059.6
2019	(2,224.5)	578.5	(756.2)	408.1	(1,468.3)	170.4
2020	(5,252.7)	2,322.0	(4,440.4)	1,978.0	(812.3)	344.0


Эх сурвалж: Нэгдсэн төсвийн 2018, 2019, 2020 оны гүйцэтгэл, Сангийн яам

1.44. Төсвийн зарлагыг нэмж, нэгдсэн төсвийг алдагдалтай баталсан нь гадаад зээл нэмэгдэх нэг шалтгаан болж, улмаар өрийн үйлчилгээний зардал өсөх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөл бий болж байна.

1.45. Төсвийн тэлэх бодлого баримталснаас нэгдсэн төсвийн зарлага 2018 онд 3.3 хувиар, 2019 онд 25.2 хувиар, 2020 онд 19.7 хувиар тус тус өссөн байна.

1.46. Урсгал зардлын ДНБ-д харьцуулсан харьцаа 2018 онд 22.7 хувь байсан бол 2020 онд 29.3 хувь, хөрөнгийн зардлын ДНБ-д харьцуулсан харьцаа 2018 онд 5.2 хувь байсан бол 2020 онд 8.2 хувь болон нэмэгджээ.

График 9. Нэгдсэн төсвийн тэнцэл ба төсвийн алдагдлыг нөхөх зээлийн ашиглалт /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Монгол Улсын 2016-2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангууд

2020 онд коронавируст (Ковид-19) цар тахал гарснаар тус салбарын санхүүжилт их хэмжээгээр өссөн нь байнгын бодлогын өсөлт биш цаг үеийн шинж чанартай арга хэмжээний өсөлт юм. /График 6/

1.50. Хүүхдийн мөнгөний нэмэгдэл, хүнсний эрхийн бичгийн үнийн дүнгийн өсөлт, төрөл бүрийн тэтгэвэр, тэтгэмжүүдийг их хэмжээгээр нэмэгдүүлж сүүлийн 5 жилийн хугацаанд нийгмийн халамжийн салбарт улсын төсвөөс зарцуулж буй зардал огцом өссөн¹⁸ байна. /График 6/

1.51. Эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан зэрэг иргэдийн амьдралыг сайжруулах, ядуурлыг бууруулах чиглэлээр улсын төсвөөс гарах зардал буурч, харин нийгмийн халамжийн шинж чанартай зардал өссөн нь улсын төсвийн зарлагын үр ашгийг бууруулж, нийгэмд тэр дундаа бага болон дунд орлоготой иргэдийн хувьд идэвхтэй хөдөлмөрлөх санаачилгыг дэмжихгүй, халамж авч амьдрах идэвхгүй иргэдийг бэлтгэж, улс орны хөгжилд үзүүлэх хувь нэмрийг бууруулж байна.

График 10. ДНБ-д эзлэх нийгмийн зардлын хувь



Эх сурвалж: Дэлхийн банкны Үндэсний санхүүжилтийн нэгдсэн тогтолцооны суурь судалгаанаас /2021 он/

байдлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал:

- **Коронавируст (Ковид-19) цар тахал гарахаас өмнө эрүүл мэндийн салбарт зарцуулсан улсын төсвийн зардлыг ДНБ-д харьцуулсан харьцаа 2.4 хувиас илүү гаргадаггүй байсан бол цар тахал болсон 2020 онд эрүүл мэндийн салбарын төсвийг нэмэгдүүлэх, яаралтай арга хэмжээ авах шаардлага үүсэж энэ харьцаа 2.7 хувьд хүрсэн нь эрүүл мэндийн салбарын эмзэг байдлыг,**

1.47. Төсвийн алдагдлыг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа өнөө үед урсгал болон хөрөнгийн зардлыг үр ашигтай зарцуулах шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

1.48. Улсын төсвөөс нийгмийн салбар тухайлбал, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарт зарцуулж буй хэмжээг ДНБ-тэй харьцуулахад буурах хандлагатай байна. /График 6/

1.49. Эрүүл мэндийн салбарын төсөв 2016 оноос хойш тогтмол буурсан боловч

1.52. Дэлхий нийтийг хамарсан коронавируст (Ковид-19) цар тахлын нөлөөлөл 2020 оноос эхлэн манай улсын эдийн засагт олон бэрхшээл дагуулж, таамаглах аргагүй нөхцөл үүсгэн эдийн засгийн эмзэг

¹⁸Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020-2021 онд өвчний тархалтыг бууруулах зорилгоор олон удаагийн хөл хорионд иргэдийн орлого тасалдаж байгаад тэтгэмжийг нэмэгдүүлж олгосон нь 2020 онд огцом өсөлттэй байдлаар харагдаж байна.

- Нийт иргэдийн 74.6¹⁹ хувь нь мөнгөн хадгаламжгүй, ядуурлын түвшин 28.4²⁰ хувь байгаа нөхцөлд цар тахлын үеийн олон удаагийн хөл хорионы үед халамж тараахаас өөр аргагүй нөхцөл байдал бий болсон нь иргэдийн орлого эмзэг байгааг,
- Экспортын орлогын 84.0 хувь, төсвийн орлогын 30.0 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүнээс бүрдүүлдэг манай орны хувьд цар тахлаас шалтгаалан улсын хилийг хаахад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт зогссон нь улсын төсвийн орлого эмзэг байгааг тус тус харуулж байна.

1.53. Коронавируст (Ковид-19) цар тахал хэдийгээр бэрхшээл боловч боломж болгон харвал манай улсын хамгийн эмзэг цэгүүдийг ил гаргаж байгаа тул эдийн засгийг өсгөх зорилгоор уул уурхайн бус орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ажил эрхлэлтийг дэмжих байдлаар улсын төсвийг үр ашигтай зарцуулах бодлогыг яаралтай авч хэрэгжүүлэн, аливаа гамшиг, хямралыг хохирол багатай давах чадамжтай нийгэм, эдийн засгийн тогтвортой суурийг бий болгох нь зүйтэй байна.

Засгийн газрын нийт өрийн үлдэгдлийн 59.1 хувийг гадаад зээл эзэлж байгаа нь ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байна

1.54. Засгийн газрын гадаад зээлийн 39.5 хувь нь ам.доллар, 27.1 хувь нь зээлжих тусгай эрх, 24.7 хувь нь иен, 5.8 хувь нь евро, 2.9 хувь нь бусад валютаас бүрдсэн байна.

1.55. Төсвийн алдагдал, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээлийг гадаад валютаар авч байгаа нь ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

1.56. Дэлхийд эрчимтэй тархаж буй шинэ төрлийн коронавируст (Ковид-19) цар тахал нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлж 2020 онд ДНБ 5.3 хувиар агшсан бөгөөд импорт 13.6 хувиар буурсан байна.

1.57. ДНБ-ний бууралтад уул уурхайн салбар 7.5 хувиар, барилгын салбар 3.6 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.9 хувиар, тээвэр 19.6 хувиар, зочид буудал болон нийтийн хоолны салбар 26.9 хувиар, бусад салбар 21.4 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

1.58. Харин 2021 оны эхний улирлын байдлаар эдийн засаг өсөлт эрчимжиж, ДНБ өнгөрсөн оны мөн үеэс 15.7 хувиар²¹, импорт 31.2 хувиар тус тус өссөн. Эдийн засаг сэргэж, импорт өссөнөөр гадаад валютын эрэлтийг өсгөж, төгрөгий ханш сулрах нөхцөлийг бий болгож байна.

1.59. Гадаад валютын эсрэг төгрөгийн ханш сулрахад дараах эрсдэлүүд бий болж болзошгүй байна. Үүнд:

- Гадаад валютын эсрэг төгрөгийн ханш 5.0 хувь сулрахад өрийн шалгуур үзүүлэлт 2022 онд 6.6, 2023 онд 5.3, 2024 онд 5.8 хувиар, 10.0 хувь сулрахад өрийн шалгуур үзүүлэлт 2022 онд 12.2, 2023 онд 14.7, 2024 онд 17.9 хувиар тус тус Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон хязгаарыг зөрчигдөх,
- Гадаад зээлийн 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл өөрчлөгдөхгүй гэж үзвэл гадаад валютын эсрэг төгрөгийн ханш жил бүр 5.0 хувь сулрахад гадаад зээлийн үлдэгдэл 2021-2024 онд 824.4-954.7 тэрбум, 10.0 хувь сулрахад 2021-2024 онд 1,649.1-2,195.4 тэрбум, 15.0 хувь сулрахад 2,470.8-3,762.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэх,
- Гадаад валютын эсрэг төгрөгийн ханш 5.0 хувь сулрахад өрийн үйлчилгээний зардал²² 2021-2025 оны хооронд 309.3 тэрбум, 10.0 хувь сулрахад 618.5 тэрбум төгрөгийн бодит ханшийн алдагдал хүлээх зэрэг эрсдэлтэй байна.

1.60. Гадаад зээлийн жигнэсэн дундаж хүү 0.78 хувь байгаа боловч өрийн зардал ханшийн өөрчлөлтөөр өсөх эрсдэлтэй бөгөөд гадаад зээлийн дундаж хугацаа 29.6 жил байгаа тул дахин санхүүжигдэх эрсдэл харьцангуй бага байна.

¹⁹ Үндэсний статистикийн хороо “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2019 оны танилцуулга”

²⁰ www.1212.mn

²¹ ДНБ өссөн нь 1) өсөлтийг тооцоход эдийн засаг өнгөрсөн оны эхний улиралд -10.7 хувь агшсан бага суурьтай харьцуулсан, 2) уул уурхай салбар 1-р улиралд 34 хувь өссөнтэй холбоотой байна. 2020 оны 2, 3-р саруудад нүүрсний экспорт зогсож, уул уурхайн салбар зогсонги байдалд орж байв. 2021 оны эхний улиралд олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ өсөж улмаар уул уурхайн салбар 15.7 хувийн өсөлтийн 7.0 хувийг дангаараа тайлбарлаж байна.

²² Жил бүр өөрчлөгдөнө.

1.61. Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2²³-т заасан Монголбанкны хэрэгжүүлэх чиг үүргийг заасан боловч тус газар 2016-2020 онд Засгийн газрын зээллэгийн хэмжээ мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөх эсэхэд дүгнэлт гаргаагүй, санал, зөвлөмж хүргүүлж ажиллаагүй байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн мэдээллийн нээлттэй, ил тод байдал хангалтгүй байна

1.62. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Төсөл хэрэгжүүлэх нэгжүүд Шилэн дансны тухай хуульд заасны дагуу 29 төрлийн мэдээллийг байршуулж, мэдээллийг ил тод болгосон эсэхийг шалгаж үзэхэд дунджаар 2018 онд 64.2 хувийг, 2019 онд 61.9 хувийг, 2020 онд 61.2 хувийг нь байршуулсан байна. Өөрөөр хэлбэл иргэд, олон нийтэд нийт мэдээллийн 62.4 орчим хувь нь харагддаг байна. /Хүснэгт 6/

Хүснэгт 6. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн шилэн дансны бүртгэл хөтлөлтийн хувь

Он	Төслийн нэгжийн тоо	Шилэн дансанд байршаагүй төслийн тоо	Шилэн дансанд байршсан төслийн тоо	29 үзүүлэлтээр шилэн дансанд мэдээлсэн хувь	Үүнээс:			
					Хугацаандаа мэдээлсэн хувь	Дутуу мэдээлсэн хувь	Хугацаа хоцорч мэдээлсэн хувь	Мэдээлээгүй хувь
2018	46	4	42	64.2	33.2	15.8	16.8	27.0
2019	58	4	54	61.9	32.0	9.3	16.3	28.3
2020	73	7	66	61.2	37.6	0.2	11.7	28.3

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

1.63. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлэх үзүүлэлтийг хамгийн бага буюу 37.0 хувьтай мэдээлсэн байна.

1.64. Төслийн нэгжгүй төсөл, арга хэмжээний мэдээлэл тухайн ТЕЗ-ийн шилэн дансны мэдээлэлд нэгтгэгдсэн байх тул мэдээлсэн тул салгаж харах боломжгүй, мэдээлэл нь нээлттэй, ил тод биш байна.

1.65. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2-т заасны дагуу Сангийн яам Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээг мэдээлэх чиг үүрэгтэй боловч тус яам ашиглалт гарсан зээлийн мэдээллийг бүрэн байршуулаагүй байна. /Хүснэгт 7/ Тухайлбал:

- 2018 онд 83 зээлээс 30 буюу 36.6,
- 2019 онд 93 зээлээс 17 буюу 18.3,
- 2020 онд 116 зээлээс 48 буюу 41.3 хувийг тус тус мэдээлээгүй байна.

Хүснэгт 7. Засгийн газрын гадаадын зээлийн ашиглалтыг мэдээлсэн байдал

/тэрбум төгрөг/

Он	Шилэн дансанд байршуулбал зохих мэдээлэл		Шилэн дансанд байршуулсан		Зөрүү	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2018	835.9	1,482.1	623.9	1,013.5	212.0	468.6
2019	1,096.3	1,639.9	1,096.8	1,361.4	-0.5	278.5
2020	1,485.4	3,368.4	1,474.3	1,965.7	11.1	1,402.7

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төслүүдэд тавих хяналт хангалтгүй байна

1.66. Сангийн сайдын 2016 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх,

²³Засгийн газрын хийх зээллэгийн хэмжээ нь Монгол Улсын мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөхүйц байх тохиолдолд тухай бүр холбогдох санал зөвлөмжийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 9.1.16-д "төсөл, арга хэмжээний үнэлгээний тайланд үндэслэн шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хөрөнгийг шийдвэрлэх, хэрэгжиж буй төслийн хяналт-шинжилгээний тайлан, зөвлөмжид үндэслэн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, санхүүжүүлэх" гэж заасны дагуу Сангийн яам 2018 онд 83, 2019 онд 79 төсөл, арга хэмжээний хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн тайланг нэгтгэн санал, зөвлөмж боловсруулжээ.

1.67. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо, дүн тогтмол өсөж, Сангийн яамны гүйцэтгэх ажлын цар хүрээ нэмэгдсэн боловч тус яамны орон тоо "Яамны зохион байгуулалтын бүтцийн орон тооны хязгаар батлах тухай" ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн тушаалаар баталсан дээд хязгаарт хүрээгүй, орон тоо дутуу байна.

1.68. Төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулах, бодлого боловсруулах, шинэ зохицуулалтыг санаачлах, хэрэгжүүлэх зэрэг Сангийн яамны хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг²⁴ гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд зөвлөх авч, өндөр зардлаар гүйцэтгүүлж байна. Тухайлбал,

- Дэлхийн банкны санхүүжилтээр 2017-2022 онд хэрэгжүүлж байгаа "Төсвийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл", "Тогтвортой амьжиргаа-3", "Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх" төслийн хүрээнд ХНХЯ, Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл зэрэг төслийн нэгжид нийт 221 зөвлөх 12.3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнээс Сангийн яамны 14 газар, хэлтэс 2018-2020 онд дотоодын 164 зөвлөхтэй /давхардсан тоогоор/ 9,620.2 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

1.69. Зөвлөх ажиллуулсан Сангийн яамны газар, хэлтсийн орон тоо, баталсан дээд хязгаарт хүрээгүй бөгөөд яамны хэмжээнд 44 орон тоо сул байна. Эдгээр сул орон тоонд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд зөвлөх ажиллуулснаар зээлийн хүүгийн төлбөрт төлсөн зардал нь нийт цалингийн зардлаас²⁵ 1.5 дахин өндөр байгаагаас үзэхэд гадаад зээлийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулж байна. Тухайлбал,

- Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2020-2021 онд ажилласан 8 зөвлөхөөр тус яамны 1927-2018 оны албан бичиг, архивын баримт, материалыг цахим хэлбэрт оруулах ажил гүйцэтгүүлсэн нь гадаад зээлийн төслийн үндсэн зорилгод нийцэхгүй, үр ашиггүй зардал болсон байна.

1.70. Иймд батлагдсан орон тооны хүрээнд төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэн хяналт тавьж, үр дүнтэй хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1.71. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд үр дүнд суурилсан хяналт, шалгалт-үнэлгээ хийх зорилгоор 2015 оноос Сангийн яаманд Удирдлагын мэдээллийн системийг²⁶ нэвтрүүлсэн байна. Гэвч ашиглалт хангалтгүй байсан тул уг системийг 2019 онд дахин шинээр хөгжүүлж төсөл, арга хэмжээг нэгдсэн байдлаар удирдах системийг 2021 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар мэдээллийн сан бүрдэж дуусаагүй, хөгжүүлэлт үргэлжилж байна.

²⁴ Засгийн газрын тухай хуулийн 20.6-д заасан Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хууль, эрх зүйн орчин, санхүүжилт, хэрэгжилт, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулах, бодлогын арга хэмжээ, шинэ зохицуулалтыг санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх

²⁵ Аудитын тооцооллоор цалингийн зардлыг сул 44 орон тооны үндсэн цалингаар дунджаар, 2018-2020 оны байдлаар тооцоолов.

²⁶ Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, шинээр хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагааг уялдуулах, давхардуулахгүй байхад шаардлагатай мэдээллээр хангах цахим мэдээллийн систем (odamis.mof.gov.mn)-ийг ойлгоно.

БҮЛЭГ 2. ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙН БҮРТГЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилт, үр дүнг тооцох аргачлал байхгүй, зохицуулалтын нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна

2.1 Монгол Улс хандивлагч орон, олон улсын байгууллагаас харилцан түншлэлийн стратегийн дагуу тусламж авч ашиглаж байна.

2.2 Хандивлагч орон, олон улсын байгууллага өөрийн орны тусламжийн бодлогыг баримтлан санхүүжилт олгодог бөгөөд манай улсын хувьд гадаад тусламжийг Төсвийн тухай хууль²⁷, Олон улсын гэрээний тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-аар²⁸ зохицуулж иржээ.

2.3 Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 5.1-д төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн хэрэгжүүлэх төслийн саналыг Сангийн яаманд хүргүүлнэ, Сангийн яам төслийн саналыг урт болон дунд хугацааны бодлогын бичиг баримт, Засгийн газрын түншлэгчтэй байгуулсан Хамтын ажиллагааны стратегийн баримт бичигтэй уялдаж байгаа эсэхийг хянаж, төслийн нийгэм, эдийн засгийн үр ашиг, зорилго, үр дүнг тооцож түншлэгчдэд санал тавихаар заасан байна.

2.4 Тус журамд тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх үе шатны дарааллыг зааж өгсөн боловч тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрхэн сонгох, үнэлэх, эрэмбэлэх аргачлалыг тусгаагүйгээс төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломжийг бууруулж байна.

Сангийн яаманд зарим тусламжийг бүртгээгүй байгаагаас өөр эх үүсвэрээс төсөл, арга хэмжээ давхар санхүүжих эрсдэлийг бий болгож байна

2.5 Сангийн яам болон төсөл хэрэгжүүлэгч байгууллага Засгийн газрын гадаад тусламжаар хэрэгжүүлж байгаа дараах 29 төсөл, арга хэмжээг төсвийн багцад тусгаагүйгээс ашиглалтын дүнг бүртгээгүй, тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцоогүй байна²⁹. Энэ нь төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс давхар санхүүжүүлэх эрсдэлийг бий болгож байна. Тухайлбал:

АТГ:

- Авлигатай тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь төсөл;

БОАЖЯ:

- Хог хаядал ба уур амьсгалын өөрчлөлт төсөл;
- “Химийн хорт болон аюултай бодисын менежментийг сайжруулах нь” төсөл;
- PlanetGOLD Монгол-Филиппин: Алтны бичил уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход оруулах хувь нэмэр: Олборлогчоос цэвэршүүлэгч рүү;
- Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь төсөл;
- Усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь төсөл;
- Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” 2-р шатны төсөл;
- Монгол Улсын Замын-Үүдийн нутаг дэвсгэр дээрх хуурай газраас үүдэлтэй Шороон болон элсэн шуургааны нөлөөг сааруулах, урьдчилан сэргийлэх төсөл;
- Тусгай хамгаалалттай газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь төсөл;

²⁷ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.53-т “гадаадын тусламж” гэж олон улсын байгууллага, түнш орноос Засгийн газрын шугамаар, эргэн төлөгдөх нөхцөлгүй, хүмүүнлэгийн болон буцалтгүй, техник туслалцааны хэлбэрээр Монгол Улсад олгож байгаа хөрөнгийн эх үүсвэрийг гэж заажээ.

²⁸ ЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-

²⁹ ЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 8.1.7. гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад, дотоод хөрөнгийн эх үүсвэрээс бүрдүүлэх санхүүжилтийг төсөл хэрэгжүүлэгч байгууллагын саналыг үндэслэн тус байгууллагын төсвийн багцад буюу төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, жилийн төсвийн хязгаар, төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, төсвийн хуваарьт тусгуулах. 9.1.12. гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаад, дотоод хөрөнгийн эх үүсвэрээс бүрдүүлэх санхүүжилтийн талаарх ТХН-ийн саналыг төсвийн хязгаар, төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, төсвийн хуваарьтаа тусган, гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

- “Парисын хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын оруулах Үндэсний хувь нэмрийн (NDC) хэрэгжилтийг хөдөө аж ахуй, газар ашиглалтын салбарт ил тод байдлаар тайлагнах, мониторингийн үндэсний чадавхыг бэхжүүлэх нь” төсөл;
- НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хэрэгжилтийн Үндэсний дөрөвдүгээр тайлан, Хүлэмжийн хийн ялгаралт, шингээлтийн нэмэлт хоёрдугаар тайлан боловсруулах төсөл;
- Монгол Улсад үндэсний хүлэмжийн хийн тооллого тооцоо хийх тогтвортой бүтцийн орчныг бий болгож, хүлэмжийн хийн тооллого тооцоог хийх чадавхыг бэхжүүлэх нь төсөл;
- Хамтарсан Кредит Олгох Механизм төсөл;
- “Монгол Улсад Монреалийн протоколыг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх нь” төсөл (10-р үе шат);
- “Монгол Улсад Монреалийн протоколыг хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг бэхжүүлэх нь” төсөл (11-р үе шат);
- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийг сааруулах төсөл;

БШУЯ:

- Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах II шат төсөл;

СЗХ:

- Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх-II төсөл;
- Бичил санхүүгийн салбарын чадавхыг сайжруулах төсөл;
- Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл;
- Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл;
- Монгол Улсын банк бус санхүүгийн байгууллагуудын эрх зүйн орчныг дэмжих төсөл;
- Тогтвортой хөгжлийг дэмжих Ногоон хөрөнгийн зах зээлийг урамшуулах бодлогын загвар ба зөвлөмжийн тухай;

ХЗДХЯ:

- Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах төсөл;
- Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, чадавхыг сайжруулах төсөл;
- “Иргэдийн оролцоо” төсөл -II үе;
- “Иргэдийн оролцоо” төсөл- төгсгөлийн үе;
- Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын чадавхыг сайжруулах төсөл;

ЭМЯ:

- Арабын эдийн засгийн Кувейтийн сангийн хөрөнгөөр ГССҮТ-ийн тоног төхөөрөмж шинэчлэх.

2.6 Төсөл хэрэгжүүлэгч байгууллага хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийг Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 5.1³⁰-д заасны дагуу бүртгүүлэх шаардлагатай бөгөөд тусламжийн ашиглах, зарцуулах, бүртгэх, тайлагнах, мэдээллийг ил тод болгох үйл ажиллагаанд Засгийн газар, Сангийн яам хяналт тавих нь зүйтэй байна.

2.7 Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 3.1-т буцалтгүй тусламжийг хүмүүнлэгийн тусламж³¹, хөгжлийн албан ёсны тусламж³², техникийн туслалцаа³³ гэж ангилахаар заасан боловч Сангийн яаманд одоо бүртгэлтэй байгаа тусламжийг ангилж бүртгээгүй, ангилал тодорхойгүй төсөл, арга хэмжээ нийт бүртгэлтэй тусламжийн 61.8³⁴ хувийг эзэлж байна.

/Хүснэгт 8/

³⁰ Төсөл хэрэгжүүлэгч байгууллага хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, төслийн техник, эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн хэрэгжүүлэх төслийн саналыг гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төслийн баримт бичгийн загвар” маягтад зааснаар боловсруулах бөгөөд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

³¹ тухайн улс, газар, оронд байгаль, эдийн засгийн хүндрэл үүссэнтэй холбогдуулан түншлэгчээс олгох буцалтгүй тусламжийг

³² хөгжиж байгаа орнуудад үзүүлж байгаа туслалцаа, тусламжийг;

³³ түншлэгчээс олгох зорилтот тусламжийг;

³⁴ Ашиглалтаар гаргасан дүн

Хүснэгт 8. Тусламжийн төрөл 2018-2020 оны ашиглалт

/тэрбум төгрөг/

№	Тусламжийн төрөл	Тоо	2018 он	2019 он	2020 он	Нийт дүн	Эзлэх хувь
1	Техник туслалцаа	7	11.2	12.9	10.9	35.1	5.4
2	Хөгжлийн албан ёсны тусламж	12	43.7	11.0	55.9	110.7	17.0
3	Хүмүүнлэгийн тусламж	3	27.6	56.6	19.0	103.2	15.8
4	Тодорхойгүй	23	26.9	22.9	353.1	402.9	61.8
	Нийт	45	109.4	103.5	439.0	651.9	100.0

Эх сурвалж: Сангийн яам

2.8 Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан буцалтгүй тусламжийн бүртгэл хангалтгүй, ангилал, төрөл тодорхойгүй байгаагаас тусламжийн ашиглалт, хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй болох эрсдэлийг бий болгож байна.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хянаж үр дүнг тооцоогүй байна

2.9 Буцалтгүй тусламжийн хүрээнд боловсролын салбарт 5680 хүүхдийн суудалтай сургууль, 100 ортой цэцэрлэг, Монгол-Японы сургалтын эмнэлгийн барилга барих, эрүүл мэндийн салбарт Түлэнхийн төвийн барилга барих, дэд бүтцийн салбарт Улаанбаатар хотын усан хангамжийг нэмэгдүүлэх зэрэг томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна.

2.10 Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 9.1.23³⁵, 24.9.2.3³⁶ дахь заалтыг тус тус зөрчин төсөл хэрэгжүүлэгч байгууллага гадаад тусламжаар төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа төслийн эцсийн тайлан гаргах, төслийн үр нөлөөний үнэлгээг хийх ажил хангалтгүй байна. Тухайлбал:

БОАЖЯ:

- Хөвсгөл нуурын цогцолбор газрын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл;
- Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь төсөл;

БШУЯ:

- Японы буцалтгүй тусламжаар Ерөнхий боловсролын сургууль байгуулах төсөл;
- Ерөнхий боловсролын сургууль барих төсөл;
- Монголын боловсролын салбар дахь ил тод байдал, эгэх хариуцлага төсөл;
- Баруун бүсийн бага насны хүүхдүүдийн дотуур байрны нөхцөлийг сайжруулах төсөл;

ЭМЯ:

- Монгол Улс дахь ковид-19 төсөл (Цар тахлын онцгой байдлын санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд олгох буцалтгүй тусламж);
- Ази номхон далайн гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах сангийн буцалтгүй тусламж;
- Ковид-19 эсрэг яаралтай хариу арга хэмжээ авах төсөл.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна

2.11 Хандивлагч орон, олон улсын байгууллагын тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хариуцах төслийн нэгжийн Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг ил тод байдлыг хангах, шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 29 мэдээллийн дундаж 2018 онд 52.9, 2019 онд 67.4, 2020 онд 49.7 хувьтай тус тус байгаагаас үзэхэд иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх мэдээллийн 56.2 хувь нь ил тод байна. /Хүснэгт 9/

³⁵ төсөл хэрэгжиж дууссаны дараа төслийн үр нөлөөний үнэлгээг хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулах.

³⁶ төсөл дуусах үед: төслийн эцсийн тайлан болон төсөл дуусахтай холбоотой бүх мэдээ, төслийн үр нөлөөний үнэлгээний талаарх мэдээллийг файлын санд.

Хүснэгт 9. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн шилэн дансны бүртгэл хөтлөлт

/хувиар/

Он	Төслийн нэгжийн тоо	Шилэн дансанд байршаагүй төслийн тоо	Шилэн дансанд байршсан төслийн тоо	29 мэдээллийг дунджаар шилэн дансанд мэдээлсэн хувь	Үүнээс:			
					Хугацаандаа мэдээлсэн хувь	Дутуу мэдээлсэн хувь	Хугацаа хоцорч мэдээлсэн хувь	Мэдээлээгүй хувь
2018	7	0	7	52.9	44.7	0	17.6	34.7
2019	9	1	8	67.4	59.1	0	13.1	23.0
2020	15	2	13	49.7	37.5	7.7	15.5	28.4

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

2.12 Төслийн нэгжгүй хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ тухайн төсөл хэрэгжүүлэгч ТЕЗ-ийн шилэн дансны мэдээлэлд нэгтгэгддэг тул салгаж харах боломжгүй, тэдгээрийн мэдээлэл ил тод, нээлттэй бус байна.

2.13 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2³⁷-т заасны дагуу Сангийн яам Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээг шилэн дансны цахим хуудсанд байршуулах үүрэгтэй боловч тус мэдээллийг цахим хуудаст нэгтгэж харуулахаар журамласнаас гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээллийг ялган харах боломжгүйгээс хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн ашиглалтын талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгоогүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр коронавируст (Ковид-19) цар тахалд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр дүнг тооцоогүй, судалгаанд суурилсан санхүүжилт хийхгүй байна

2.14 УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 21 дүгээр тогтоолоор коронавируст (Ковид-19) цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээг баталсан байна.

2.15 Тус тогтоолд гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр доорх зардлыг санхүүжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 10. Цар тахлын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Дэд зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гадаад зээл, тусламж дүн	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах	Эмнэлгийн багаж тоног төхөөрөмж	159.0	54.8
	Эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хэрэгсэл	20.6	3.5
	Хүнсний эрхийн бичиг	-	13.7
II. Иргэдийн орлогыг хамгаалах	Цалин урамшуулал	-	2.4
	Хүүхдийн мөнгө	-	75.6
	Ажилгүйдлийн тэтгэмж	-	4.3
III. Ажлын байрыг хадгалах	Албан журмын даатгалын шимтгэл чөлөөлөлт	-	28.5
	Сайн дурын даатгалын шимтгэл чөлөөлөлт	-	42.6
IV. Эдийн засгийг идэвхжүүлэх	Төсвийн дэмжлэг	3,100.0	2,032.0
НИЙТ ДҮН		3,279.6	2,257.5

Эх сурвалж: Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.16 Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулан гадаадын зээл, тусламжаар нийт 2,257.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосноос төсвийн дэмжлэгт 2,032.1 тэрбум төгрөг, хэрэгжиж байгаа болон шинээр эхэлсэн 12 төсөлд 225.4 тэрбум төгрөг олгосон байна. Үүнээс 215.7 тэрбум төгрөгийн дүнтэй 9 зээл, 9.8 тэрбум төгрөгийн 3 тусламж байна.

³⁷ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 6.1, 6.4-т заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг гаргана: 6.5.2.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээг улирал бүр;

Хүснэгт 11. Гадаадын зээл, тусламжаар санхүүжүүлсэн цар тахалтай тэмцэх төсөл, арга хэмжээний судалгаа

№	Санхүүжүүлэгч байгууллага	Төслийн нэр	Төрөл	Хэрэгжүүлэгч байгууллага	Зарцуулалт/Гүйцэтгэл		Хэрэгжилтийн хувь	Үр дүн
					ам.доллар /мянган/	төгрөг /сая/		
1	Хэрэгжиж байсан төслөөс:							
1.1	АХБ	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 5 төсөл	зээл	ЭМЯ	1,190.1	3,317.5	100	Хавсралтаас үзнэ үү
1.2	ДБ	Цахим эрүүл мэнд төсөл	зээл	ЭМЯ	2,109.9	5,930.6	100	Хавсралтаас үзнэ үү
1.3	ДБ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	зээл	ХНХЯ	15,000.0	42,632.4	100	21 аймаг, 9 дүүргийн Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчид зэрэг албан бус салбарт ажиллагч, сайн дурын даатгуулагч 120.939-156.488 иргэний нийгмийн даатгалын шимтгэлийг 6 сарын хугацааны хөнгөлөлт тэтгэмж
1.4	ДБ	Боловсролын чанарын шинэчлэл төсөл	зээл	БШУЯ	5,000.0	14,240.0	100	Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн 10 дугаар сарын санхүүжилтэд зарцуулж, 1,168,109 хүүхдэд олгосон
1.5	ДБ	Экспортын дэмжих төсөл	зээл	ХХААХҮЯ	1,500.0	4,267.5	100	332 ААНБ-ын 400 гаруй даатгуулагчид олгосон /БЗД, ХУД/
Хэрэгжиж байсан төсөл, арга хэмжээний нийт дүн					24,800.0	70,388.0		
2	Шинээр эхэлсэн төслөөс:							
2.1	АХБ	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 5 төсөл - Яаралтай тусламжийн төсөл	зээл	ЭМЯ	10,008.7	28,555.1	43	Хавсралтаас үзнэ үү
2.2	ДБ	Монгол Улсад COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	зээл	ЭМЯ	4,637.6	13,217.2	73	Хавсралтаас үзнэ үү
2.3	АХБ	Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл	зээл	ХНХЯ	26,400.0	75,018.1	100	Хүүхдийн мөнгө хөтөлбөрийн 4, 5, 6, 8, 9, 10 дугаар сарын хүүхдийн мөнгөний санхүүжилтэд зарцуулж, 1,186,289 хүүхдэд олгосон. Эмзэг бүлгийн 180,000 гаруй иргэдэд 2020.05-09 сарын хооронд хүнсний эрхийн бичиг олгосон
2.4	ДБ	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	зээл	ХНХЯ	10,000.0	28,496.9	100	20 аймаг, 5 дүүргийн 23913 ажил олгогчдын 350,657 даатгуулагчийн 2020 оны 9 дүгээр сарын албан журмын даатгалын НДШ-ийн чөлөөлөлт
2.5	АХБ	Ази номхон далайн гамшигын эсрэг хариу арга хэмжээ авах сангийн буцалтгүй тусламж	тусламж	ЭМЯ	1,500.0	4,267.5	100	Хавсралтаас үзнэ үү
2.6	АХБ	Ковид-19 эсрэг яаралтай хариу арга хэмжээ авах төсөл	тусламж	ЭМЯ	1,000.0	2,781.6	100	2541 эмнэлгийн ажилтанд илүү цагийн урамшуулал олгосон
2.7	ДБ	Монгол Улс дахь КОВИД-19 төсөл (Цар тахлын онцгой байдлын санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд олгох буцалтгүй тусламж)	тусламж	ЭМЯ	927.9	2,706.6	100	Хавсралтаас үзнэ үү
Шинээр эхэлсэн төсөл, арга хэмжээний нийт дүн					54,474.2	155,043.0		
Нийт хэрэгжиж байсан болон шинээр эхэлсэн төслийн дүн					79,274.2	225,431.0		

Эх сурвалж: Аудитын тооцоолол

2.17 Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хүүхдийн мөнгө хөтөлбөрт 75.6 тэрбум, 507.1 мянган даатгуулагчийн албан журмын болон сайн дурын нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтөд 71.1 тэрбум, 332 аж ахуй нэгж, байгууллагын 400 гаруй даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжид 44.1 тэрбум, эмзэг бүлгийн 180.0 мянга гаруй иргэдийн хүнсний эрхийн бичигт 13.7 тэрбум төгрөг тус тус зарцуулсан бол эмнэлгийн салбарт 60.7 тэрбум төгрөг зарцуулсан нь нийт санхүүжилтийн 2.7 хувийг эзэлж байна.

2.18 Эмнэлгийн 54.5 мянган ширхэг тоног төхөөрөмжийг 54.8 тэрбум, 4.6 сая ширхэг эмнэлгийн хэрэгслийг 3.5 тэрбум төгрөгөөр тус тус худалдан авч, эмнэлгийн байгууллагуудад нийлүүлж, ЭМЯ болон салбарын 2541 ажилтны илүү цагийн хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн өр төлбөр, урамшуулалд 2.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү/

2.19 Эрүүл мэндийн салбарын 1 ажилтанд 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдөр хүртэлх 2.5 сарын хугацаанд дунджаар 0.2-3.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/309, А/337, А/395 дугаар тушаалаар олгосон байна.

2.20 Коронавируст (Ковид-19) цар тахлын хүнд нөхцөлд гол ачааллыг үүрч ажиллаж байгаа “Халдварт өвчин судлалын үндэсний төв”-ийн 752 ажилтанд дунджаар 1.3 сая төгрөг олгосон

бөгөөд 2020 оны 5-8 сарын хугацаанд бусад эмнэлгүүдийн ачаалал бага байх үед ажлын ачааллыг харгалзахгүйгээр илүү цагийн хөлсийг харилцан адилгүй буюу 1 ажилтанд 1.0-3.4 сая төгрөгийг олгосон байна. Тухайлбал:

- Улсын клиникийн 1 дүгээр төв эмнэлгийн 1 ажилтанд дунджаар 3.4 сая төгрөг;
- Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 1 ажилтанд 3.2 сая төгрөг;
- Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын 1 ажилтанд 2.6 сая төгрөг;
- Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн 1 ажилтанд 2.3 сая төгрөг;
- Эрүүл мэндийн яамны 1 ажилтанд 1.8 сая төгрөг;
- Гэрээт ажилтанд 1.5 сая төгрөг;
- Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын 1 ажилтанд 1.5 сая төгрөг;
- Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 1 ажилтанд 1.3 сая төгрөг;
- Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 1 ажилтанд 1.0 сая төгрөг;
- Бусад нэр бүхий 12 байгууллага, аймгийн Нэгдсэн эмнэлгийн 1 ажилтанд 0.2-0.9 сая төгрөг.

2.21 Эмч, эмнэлгийн ажилтан бус ЭМЯ-ны удирдлагын багийн эрх бүхий 18 албан тушаалтанд дунджаар 1.8 сая төгрөг, нийт 33.0 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг ЭМЯ-ны ТНБД-ын 2020 оны А/61, А/76, А/95 дугаар тушаалаар олгосон байна.

2.22 Цаашид коронавируст (Ковид-19) цар тахлын хүнд нөхцөлд ажиллаж байгаа эрүүл мэндийн салбарын ажилтны ажиллах нөхцөлийг сайжруулж, цалин, илүү цагийн хөлс, урамшууллыг ажлын ачааллыг харгалзан бодитой тооцож олгох, эмнэлгийн ажилтан бус удирдах түвшний албан тушаалтанд урамшуулал олгохгүй байхад анхаарах шаардлагатай байна.

2.23 Эмнэлгийн тоног төхөөрөмжид 54.8 тэрбум төгрөг зарцуулсан ч энэ нь эмнэлгүүдэд хүрэлцээтэй эсэх, өвчтөн нэг бүрд хүрч байгаа эсэх талаар судалгаа, тооцоо гаргаагүй, хуваарилсан эмнэлгүүдийн одоогийн хүчин чадал зэргийг тооцсон баримт, судалгаа хийгээгүй байна.

2.24 Коронавируст (Ковид-19) цар тахлын улмаас гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэл судалгааг гаргаж, хэрэгцээ шаардлага, хүртээмж, үр дүнг тооцож, цаашид үр дүнд хүргэхийн тулд судалгаанд суурилан санхүүжилтийг хийх шаардлагатай байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2021.08.04 № 10/4407

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА

Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоолын дагуу Үндэсний аудитын газраас “Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад, саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 4 хуудас.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ

9762001042

“ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

**ҮАГ-ын тайлбар
1-ийг үзнэ үү.**

1. Олон Улсын Валютын Сангаас 2017-2020 онд хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд гадаад зээл, тусламжийн төслүүд болон тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Түүнчлэн, Дэлхий дахинаа 2020 онд “Ковид-19” цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор нийгэм, эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналтын салбаруудад нэмэлт санхүүжилт шаардлагатай болж, гадаад зээл, тусламжийн гэрээг нэмэлтээр байгуулж байна. Тиймээс, тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газраас явуулж буй бодлогын хүрээнд аудитын тайлангийн гарчгийг **“Бодлогын шийдвэрийн хүрээнд гадаад зээл, тусламж нь улсын төсвийн тодорхой хэсгийг бүрдүүлсэн хэвээр байна”** гэж өөрчлөх;

**ҮАГ-ын тайлбар
2-ыг үзнэ үү.**

2. Гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах зорилгоор “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулсан бөгөөд журам 2021 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэн. Шинэчлэн баталсан журамд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд тавигдах шаардлага илүү нарийвчилж тусгасан. Тухайлбал, Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан шаардлага болон харьяалах төрийн захиргааны төв байгууллага нь хууль, энэ журамд заасан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг салбарын хөгжлийн бодлого, зорилт, тэргүүлэх чиглэл болон өмнө хэрэгжсэн төслүүдтэй уялдуулах, давхардуулахгүй байх, салбарын болон салбар хоорондын зохицуулалтыг хангах үүргийн дагуу хянан, тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж байх, Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, хөгжлийн түншийн хамтын ажиллагааны бодлого, стратегитай нийцэж байх, төсөл, арга хэмжээний төрлөөс хамааран бүтээн байгуулалт, барилгын ажлыг гүйцэтгэх газрыг шийдвэрлэсэн байх зэрэг шаардлагуудыг илүү нарийвчилж тусгасан. Мөн төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг эрэмблэх аргачлал боловсруулахаар ажиллаж байгаа тул гадаад зээлээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх эрхзүйн орчныг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авсан талаар нэмж тусгах;

**ҮАГ-ын тайлбар
3-ыг үзнэ үү.**

3. Төсвийн тухай хуулийн 28.1-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т төсөвт өртөг нь 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөл, арга хэмжээг тусгахаар заасан бөгөөд түүнээс доош өртөгтэй төсөл, арга хэмжээг хэрхэн санхүүжүүлэх талаар хуулийн зохицуулалт байхгүй байна. Иймд 1.10 дахь дүгнэлтэд байгаа Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтаас 30.0 тэрбум төгрөгөөс доош төсөвтэй төсөл, арга хэмжээг хасах;

**ҮАГ-ын тайлбар
4-ийг үзнэ үү.**

4. Аудитын тайланд дурдсан дүгнэлт тус бүрийн жишээ төсөл, арга хэмжээний жагсаалт дахь төслийн тоог багасгаж, төсөл, арга хэмжээг багцлан дүгнэх;

**ҮАГ-ын тайлбар
5-ыг үзнэ үү.**

5. Засгийн газрын гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гэрээ хэлэлцээрийг хийхээс өмнө төсөл, арга хэмжээний шинж чанараас хамааран Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.7-д заасан нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ, анхан шатны ТЭЗҮ, судалгааг санхүүжүүлэгчийн зүгээс олгодог буцалтгүй тусламж болон бэлтгэл ажил хангах техник туслалцааны хүрээнд хийдэг. Харин, төслийн хүрээнд хийгдэх барилга байгууламж, дэд бүтцийн нарийвчилсан зураг төсвийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Гэвч, зарим тохиолдолд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан зээлийн хөрөнгөөс санхүүлэхээр тохиролцож, хэрэгжүүлэх шаардлага үүсдэг. Тиймээс, аудитын тайлангийн 1.13 дахь дүгнэлтэд гадаад зээл, тусламжаар тухайн төслийн хүрээнд хийгдэх барилга байгууламж, дэд бүтцийн төсөл, арга хэмжээний нарийвчилсан зураг төсвийг санхүүжүүлэх болсон шалтгааныг нэмж тусгах;

**ҮАГ-ын тайлбар
6-г үзнэ үү.**

6. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн гэрээ байгуулах, батлуулах үйл ажиллагаанд Монгол Улсын хууль болон тухайн санхүүжүүлэгч байгууллагын дүрэм, журмыг дагаж мөрддөг учраас аудитын тайлангийн 1.16 дахь дүгнэлтийг хасах;
7. Дэлхийн Банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Монгол Улсад COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл"-ийн хэрэгжилт нь аудитын хамрах хүрээнд хамааралгүй тул аудитын тайлангийн 1.44 дэх дүгнэлтийн жишээ төсөл, арга хэмжээний жагсаалтаас хасах;
8. Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд хөгжлийн түнш улсдаас харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго бүхий экспортын зээл олгодог бөгөөд тус зээл нь хөнгөлөлттэй эсвэл нэн хөнгөлөлттэй нөхцөлтэй байдаг боловч зээлийн санхүүжилтийн тодорхой хувийг тухайн улсын гарал үүсэлтэй бараа, үйлчилгээ худалдан авахад зориулах, тухайн улсын аж ахуйн нэгжүүд гүйцэтгэгчээр ажиллах зэрэг нөхцөлийг зээлийн гэрээнд тусгадаг учраас 1.45, 1.46 дахь дүгнэлтийг "Хөгжлийн түнш орноос олгож буй зээл нь хоёр талын харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилго бүхий экспортын зээл бөгөөд бусад зээлийн эх үүсвэртэй харьцуулахад харьцангуй өндөр хөнгөлөлттийн түвшинтэй байдаг боловч санхүүжилтийн тодорхой хэсгээр зээлдүүлэгч орны гарал үүсэлтэй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг худалдан авах, тухайн орны аж ахуйн нэгж гол гүйцэтгэгч байх зэрэг нөхцөлийг зээлийн гэрээнд зээлдүүлэгч талаас тусгадаг байна" гэж найруулах;
9. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь Засгийн газрын гадаад зээл, тусламжаар хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээний үр нөлөөний үнэлгээний тайланг 2-3 жилийн дараа хараат бус мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж гаргуулахаар холбогдох журамд заасан бөгөөд 1.50, 2.11 дэх дүгнэлт дэх "зөрчин" гэсэн үгийг "дагаж мөрдөөгүйгээс" гэсэн үгээр сольж, төсөл арга хэмжээний жагсаалтаас Үр нөлөөний тайлан гаргах хугацаа нь болоогүй төсөл, арга хэмжээг хасах;
10. Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагаас тухайн орны нийгэмд чухал ач холбогдол бүхий бага дүнтэй хүмүүнлэгийн болон техник туслалцааны төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг. Уг төсөл арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилтэд тухайн олон улсын болон хүмүүнлэгийн байгууллага хяналт тавьдаг бөгөөд техник туслалцааны болон хүмүүнлэгийн төслүүдийг Сангийн яам хянах эрхгүй учраас 2.5 дахь дүгнэлтийг "Олон улсын болон хүмүүнлэгийн байгууллагын дотоод журмын дагуу хяналт тавьж хэрэгжүүлж байгаа 4,524.4 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээ бүртгэлгүй байгаа бөгөөд төсөл хэрэгжүүлэгч байгууллага дээрх төслүүдийн ашиглалтыг бүртгэж, тайлагнаагүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцоогүй байна" гэж найруулах;
11. Дэлхийн Банкны 60840-MN болон 60850-MN тоот хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Монгол Улсын Засгийн Газар Дэлхийн Банктай хамтран Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийг 2017-2022 онд хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд дэд бүтэц, байгаль орчин, төрийн үйлчилгээ, санхүүгийн салбарт хийгдэх шинэчлэл, чадавхыг бэхжүүлэх, удирдлага зохион байгуулалтын нэгдмэл байдлыг хангахад чиглэгдсэн зөвлөх үйлчилгээг санхүүжүүлдэг¹ бөгөөд төслийн Санхүүгийн хэлэлцээрт Худалдан авах ажиллагааны холбогдох журам, бодлого, зарчмын хүрээнд төслийн хэрэгжилтэд шаардлагатай бараа, ажил, зөвлөх болон зөвлөхийн бус үйлчилгээг худалдан авах санхүүжилтийн явцыг нарийвчлан тусгасан байна. Сангийн яаманд тус төслийн хүрээнд ажиллаж байгаа зөвлөхүүд нь 1) Мэдээлэл, хяналт, бүртгэл, төлбөр, мониторинг зэрэг мэдээллийн системүүдийг хөгжүүлж нэвтрүүлэх.

ҮАГ-ын тайлбар
7-г үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
8-ыг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
9-ийг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
10-ыг үзнэ үү.

ҮАГ-ын тайлбар
11-ийг үзнэ үү.

ажиллуулах 2) Олон улсын шилдэг туршлага, стандарт нэвтрүүлэх, зөвлөх 3) төсөв, санхүү, нийгмийн хамгааллын салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах 4) Судалгаа, төлөвлөгөө боловсруулах, 5) байгууллага, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр ажиллаж байна. Төслийн үнэлгээний бичигт Сангийн яамны мэдээлэл, технологийн тоног төхөөрөмж, эд хогшлыг шинэчлэн, төрийн үйлчилгээг зардал багатай, хялбар шуурхай оновчтой зохион байгуулах бүтэц зохион байгуулалтын шинэчлэлийг хэрэгжүүлэхээр заасан. Энэ хүрээнд Дэлхийн банкны шинжээч нартай хамтран байгууллага, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх хүрээнд Сангийн яамны архивыг цахим болгох, олон жил хадгалагдсан архивын мэдээллийг цэгцлэх, бүртгэлийг сайжруулах, мэдээллийг цахим болгох зөвлөхүүдийн ажлын даалгаврыг боловсруулж энэ ажлыг хийж чадах дотоодын зөвлөхүүдийг нээлттэй сонгон шалгаруулж харьцангуй зардал багатай амжилттай хэрэгжүүлсэн. Энэ ажлыг хийх дотоодын зөвлөхүүд нь мэргэжлийн, хэлний, орчин үеийн цахим архивын мэдээлэл шаардсан бөгөөд дотоодын зөвлөхүүд АЗ болон А4 хэмжээтэй нийт 550,000 гаруй нүүр хуудас төсөв, санхүүгийн цаасан суурьт баримтуудыг архиваас хүлээн авч, цахим хэлбэрт шилжүүлэн, буцааж стандартын дагуу үдэн архивд хүлээлгэж өгсөн. Сангийн яамны архив орчин үеийн найдвартай тоног төхөөрөмжтэй болж, мэдээлэл нь бүрэн цахим болсон. Энэ төслийн үр шим хүртэгч байгууллагын чадавхыг бэхжүүлэх төслийн зорилгод бүрэн нийцсэн хэмээн Дэлхийн банк өндөр үнэлсэн болно. Түүнчлэн, Сангийн яамны нийт батлагдсан орон тоо 167 бөгөөд одоо 160 албан хаагч ажиллаж байна. Сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах зарыг төрийн албаны зөвлөл рүү хүргүүлэхээр ажиллаж байгаа учраас тайлангийн 1.77, 1.78 дүгнэлтийг жишээний хамт хасах;

Сангийн яамнаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

ҮАГ-ын тайлбар 1

Ирүүлсэн саналтай танилцан тайлангийн гарчгийг “ТӨСВИЙН АЛДАГДЛЫГ БУУРУУЛАХАД ДЭМЖЛЭГ БОЛОХУЙЦ ҮР АШИГТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРЭН БҮРДЭЭГҮЙ, ЦОГЦ БОДЛОГОГҮЙ БАЙНА” гэж өөрчилсөн.

ҮАГ-ын тайлбар 2

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн 1.2-т “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх хяналт тавих, үнэлэх журам”-ыг 2021 оны 1 дүгээр сард шинэчилж баталжээ.” гэж тусгасан.

ҮАГ-ын тайлбар 3,4

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн 1.7-т өөрчлөлт оруулсан болно.

ҮАГ-ын тайлбар 5

Ирүүлсэн санал тайлбар аудитын тайлангийн утга санаатай ижил тул өөрчлөлт оруулаагүй болно.

ҮАГ-ын тайлбар 6

Ирүүлсэн саналыг хүлээн авлаа.

ҮАГ-ын тайлбар 7

Аудитын явцад илэрсэн зөрчил нотлох баримтаар баталгаажсан тул саналыг хүлээн авах боломжгүй.

ҮАГ-ын тайлбар 8

Ирүүлсэн санал тайлбар аудитын тайлангийн утга санаатай ижил тул өөрчлөлт оруулаагүй болно.

ҮАГ-ын тайлбар 9

Ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн 1.30, 2.10 дахь хэсгийн найруулгыг өөрчилсөн.

ҮАГ-ын тайлбар 10

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа гарах үр нөлөөг үнэлэх аргачлал болон үе шаттай үнэлэх хугацааг журамд тодорхой болгох шаардлагатай тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй.

ҮАГ-ын тайлбар 11

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо, дүн тогтмол өсөж, Сангийн яамны гүйцэтгэх ажлын цар хүрээ нэмэгдсэн боловч тус яамны орон тоо “Яамны зохион байгуулалтын бүтцийн орон тооны хязгаар батлах тухай” ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн тушаалаар баталсан дээд хязгаарт хүрээгүй, орон тоо дутуу байгаа нь холбогдох нотлох баримтаар баталгаажиж байгаа тул ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т “Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох” гэж заасан боловч УИХ-аас Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, зорилттой уялдуулсан гадаад зээлийн талаар баримтлах бодлогыг батлаагүй байна.
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гадаад зээл, тусламжийг түлхүү ашиглаж байгаа нь өрийн ачааллыг нэмэгдүүлж буй тул санхүүжилтийн бусад эх үүсвэр ашиглах бодит шаардлага бий болсон байна.
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй 30.0 тэрбум төгрөгөөс доош өртөгтэй төсөл, арга хэмжээг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалтгүйгээс Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5.3-т заасан шаардлага хэрэгжихгүй байна.
- Засгийн газрын шугамаар шинээр авах зээл нь гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хүсэлт илгээхэд төслийн баримт бичгийг ямар түвшинд боловсруулсан байх, техник, эдийн засгийн үндэслэлийг төслийн аль үе шатанд хийх, баримт бичгийн үнэлгээг хэрхэн хийх талаарх хуульд нийцсэн аргачлал байхгүйгээс Өрийн удирдлагын тухай хуулийн 18.5.3, 18.5.4, 18.5.7-д заасан шаардлага хангасан эсэх дүгнэлтийг Сангийн яам гаргадаггүй байна. Энэ нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширч, үр дүнд сөргөөр нөлөөлж байна
- Сангийн яам гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулахдаа Засгийн газрын 2006 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ын 4.2, 4.9, 4.10, 4.11-т заасныг мөрддөггүй, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт болон хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах ажлыг зохион байгуулах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүйгээс нийт дотоодод дамжуулан зээлсэн зээлийн 47.0 хувь нь эргэн төлөгдөөгүй, энэ нь улсын төсөвт ачаалал үүсгэж байна.
- Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-т заасныг үндэслэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар 2018-2019 онд хандивлагч орон, олон улсын байгууллагаас нийт 882.9 тэрбум төгрөгийн гадаад зээл авсан бол 2020 онд түүнээс 2.2 дахин их буюу 1,978.1 тэрбум төгрөгийн зээлийг авч ашигласан нь сүүлийн 3 жилд ашигласан нийт гадаад зээлийн 44.1 хувийг эзэлж байна. Гадаад зээлийн хөрөнгөөр төсвийн алдагдлыг санхүүжүүлж байгаа өнөө үед улсын төсвөөс зарцуулах нийгмийн халамжийн зардал өсөж, төсвийн үр ашиг урт болон дунд хугацаанд буурч байна.
- Дэлхий нийтийг хамарсан коронавируст (Ковид-19) цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 онд буурсан боловч 2021 оны эхний улирлын байдлаар өсөх хандлага ажиглагдаж, эдийн засаг сэргэж гадаад валютын эрэлтийг өсгөж, төгрөгийн ханш сулрах нөхцөл бүрдэж байгаа үед Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон хязгаар зөрчигдөх, гадаад валютын эсрэг төгрөгийн ханш 5.0 хувь сулрахад өрийн үйлчилгээний зардал 2021-2025 оны хооронд 309.3 тэрбум, 10.0 хувь сулрахад 618.5 тэрбум төгрөгийн бодит ханшийн алдагдал хүлээх, төсвийн ачаалал нэмэгдэх эрсдэлтэй тул зээлийг үр ашигтай зарцуулах нь чухал байна.
- Гадаад тусламжаар хэрэгжүүлж байгаа 29 төслийг төсвийн багцад тусгаагүйгээс ашиглалтын дүнг бүртгэдэггүй, тайлагнадаггүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэггүй нь улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс төслийг давхар санхүүжүүлэх эрсдэлтэй байна.

- Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.2-т заасны дагуу Сангийн яам мэдээлэх чиг үүрэгтэй боловч зээл, тусламжийн ашиглалтын мэдээллийг бүрэн байршуулаагүй, 2018-2020 оны байдлаар 3,024.8 тэрбум төгрөгийн зээл, тусламжийн ашиглалтыг мэдээлээгүй, иргэд, олон нийтэд мэдээллийг нээлттэй, ил тод болгоогүй байна.
- Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тоо, дүн тогтмол өсөж, Сангийн яамны гүйцэтгэх ажлын цар хүрээ нэмэгдсэн боловч тус яамны орон тоо дээд хязгаартаа хүрээгүй, дутуу, төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулах, бодлого боловсруулах, шинэ зохицуулалтыг санаачлах, хэрэгжүүлэх зэрэг амны хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийг³⁸ гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд зөвлөх авч, өндөр зардлаар гүйцэтгүүлснээр зээлийн хүүгийн төлбөрт төлсөн нийт зардал нь цалингийн зардлаас³⁹ 1.5 дахин өндөр байгаагаас үзэхэд гадаад зээлийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулж байна.

³⁸ Засгийн газрын тухай хуулийн 20.6-д заасан Засгийн газрын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй ТАХ-ний хууль, эрх зүйн орчин, санхүүжилт, хэрэгжилт, зохион байгуулалтын тогтолцоог сайжруулах, бодлогын арга хэмжээ, шинэ зохицуулалтыг санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх

³⁹ Аудитын тооцооллоор цалингийн зардлыг сул 44 орон тооны үндсэн цалингаар дунджаар, 2018-2020 оны байдлаар тооцоолов.

Улсын Их Хурлын анхааралд толилуулах нь:

- Хөгжлийн урт хугацааны бодлогод туссан зорилтуудыг гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх бодлого алдагдах эрсдэлтэй байгаа тул Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг боловсруулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлэх;
- Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар 2018-2020 онд нийт 2,861.1 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, төсвийн алдагдлыг нөхсөн боловч эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан зэрэг иргэдийн амьдралыг сайжруулах, ядуурлыг бууруулах чиглэлээр улсын төсвөөс гарах зардал буурч, харин нийгмийн халамжийн шинж чанартай зардал өссөн нь улсын төсвийн зарлагын үр ашгийг дунд болон урт хугацаанд бууруулж буй тул гадаад зээлийн хөрөнгийг хөгжлийн бодлого, зорилттой уялдуулж, эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, хуулийн шаардлага хангахгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй төсөл, арга хэмжээнд төсөв батлахгүй байхад анхаарах;

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монголбанкнд:

1. Өрийн удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 -т заасан Монголбанкнаас хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу Засгийн газрын зээллэгийн хэмжээ мөнгөний болон валютын зах зээлд нөлөөлөх эсэхэд дүгнэлт гарган санал, зөвлөмж хүргүүлэн ажиллах;

Монгол Улсын Ерөнхий сайдад:

2. Өрийн удирдлагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-т заасан “Засгийн газрын гадаад зээлийн талаар төрөөс баримтлах бодлого”-г боловсруулах;
3. Төгрөгийн ханш сулрах нөхцөлийг бууруулах үр дүнтэй, иж бүрэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх;
4. Төсөл, арга хэмжээг гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, төслийн хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах;
5. Гадаад зээлийн хөрөнгөөр дотоодод дамжуулан зээлдүүлсэн эргэн төлөлт хийгдээгүй 73 зээлийг барагдуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах;
6. Улсын хэмжээнд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр коронавируст (Ковид-19) цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн ашиглалт, үр дүнд хяналт хийж, тайлагнах;

Сангийн сайдад:

7. Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх 30.0 тэрбум төгрөгөөс доош өртөгтэй төсөл, арга хэмжээг сонгох, төсөвт өртгийг тооцох, үнэлэх, эрэмбэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг үнэлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;
8. Гадаад зээлийн хөрөнгийг хөгжлийн бодлого, түүний зорилттой уялдуулж, эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хуулийн шаардлага хангахгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй төсөл, арга хэмжээнд төсөв хуваарилахгүй байх;

9. Дамжуулан зээлийн авлагын тайлангаас эргэн төлөлт хийгдээгүй зээл тус бүрийн төлөгдөхгүй байгаа учир шалтгааныг тодруулж, эзэн холбогдогч нь тодорхой зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах;
10. Засгийн газрын гадаад тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг тусламжийн төрөл тус бүрээр бүрэн бүртгэх, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах;
11. Сангийн яамны үндсэн чиг үүргийн ажлыг гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн зөвлөхөөр гүйцэтгүүлэх байдлыг таслан зогсоож, сул орон тоог нөхөж, бүрэн орон тоогоор үндсэн чиг үүргийн дагуу ажиллах;
12. Гадаад зээл, тусламжийн ашиглалтын талаарх мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд ойлгомжтой байршуулахгүй байгаад анхаарч, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах;

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан гадаад зээлийн хөрөнгийн ашиглалт /салбараар, тэрбум төгрөг/

№	Санхүүжүүлэгч байгууллага	Нийт дүн	Салбарууд:																		
			Аж үйлдвэр	Аялал жуулчлал	Банк, санхүү	Боловсрол	Дэд бүтэц	Зам тээвэр	Нийгмийн хамгаалал	Санхүүгийн салбар	Төрийн удирдлага	Төсвийн дэмжлэг	Ус хангамж, хотын дэд бүтэц	Үйлдвэр худалдаа	Харилцаа холбоо	Хотын хөгжил	Хөдөө аж ахуй	Худалдаа, эдийн засаг	Эрүүл мэнд	Эрчим хүч	Бусад
1	АХБ	5,964.3	-	28.2	101.4	174.1	-	692.2	1,042.5	141.8	511.1	-	381.8	15.5	16.0	324.1	1,459.3	95.4	482.9	498.1	-
2	ЖАЙКА	4,840.9	117.1	-	-	214.5	-	961.0	-	-	-	1,129.0	-	-	-	-	-	1,078.6	-	1,340.7	-
3	БНХАУ	2,875.3	-	-	-	307.8	69.5	1,307.1	-	-	-	-	44.0	-	79.9	86.8	689.5	-	20.6	270.0	-
4	ДБ	2,510.4	-	-	533.1	36.6	74.8	192.3	180.7	386.5	86.7	147.3	-	-	-	169.8	113.0	242.8	141.0	197.9	7.7
5	Кре. Свисс	686.6	-	-	-	-	-	-	-	-	-	686.6	-	-	-	-	-	-	-	-	-
6	Солонгос	534.3	-	-	-	5.4	-	71.0	-	-	-	8.9	-	-	164.2	-	-	-	18.3	266.5	-
7	Герман КФВ	445.5	-	-	-	-	-	21.6	-	18.0	-	-	-	107.5	100.9	-	-	64.4	-	133.1	-
8	АХУБ	286.1	-	-	-	-	-	-	-	-	-	286.1	-	-	-	-	-	-	-	-	-
9	ОУВС	284.7	-	-	-	-	-	-	-	-	-	284.7	-	-	-	-	-	-	-	-	-
10	Австри	216.8	-	-	-	-	-	-	-	-	-	-	2.5	-	-	68.2	-	-	128.6	-	17.6
11	Франц	191.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	162.5	-	-	5.5	-	23.8
12	Кувейт сан	173.1	-	-	-	-	-	117.2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	55.8	-
13	Энэтхэг	150.3	8.1	-	-	-	-	-	-	-	-	64.2	-	-	78.0	-	-	-	-	-	-
14	ХААХУСан	102.0	-	-	-	-	-	-	29.9	-	-	-	-	-	-	-	72.1	-	-	-	-
15	НХСан	97.5	-	-	-	16.2	-	15.8	15.5	-	-	-	-	-	20.0	-	-	-	-	29.9	-
16	ЕХУБанк	86.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	86.7	-	-	-	-	-
17	Польш	61.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	9.8	-	-	-	-	52.1
18	Испани	49.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	49.9	-	-	-	-	-	-	-	-
19	ЖБИК	41.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	41.9	-	-	-
20	Абу-Дабй	37.2	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	37.2	-
21	ЕСБХБанк	23.0	-	-	-	-	-	22.8	-	-	-	-	-	-	-	0.3	-	-	-	-	-
22	Беларусь	21.5	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	21.5
23	Бельги	16.1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	16.1	-	-
24	Швед	8.3	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	8.3	-
	Нийт	19,706.1	125.2	28.2	634.5	754.7	144.3	3,401.0	1,268.6	546.3	597.8	2,606.8	478.2	123.0	458.9	908.2	2,333.9	1,523.1	813.1	2,837.7	122.7

Хавсралт 2. Гадаад зээлийн хөрөнгийн ашиглалтын хувь /салбараар/

Салбар	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
Зам тээвэр	70.5%	62.4%	34.6%	42.2%	14.5%
Эрүүл мэнд	8.3%	4.7%	12.4%	3.8%	9.0%
Эрчим хүч	3.6%	5.5%	24.2%	12.1%	5.6%
Боловсрол	3.4%	5.6%	2.5%	6.7%	4.0%
Банк, санхүү	2.1%	0.8%	5.1%	3.3%	3.4%
Хөдөө аж ахуй	2.0%	6.1%	6.4%	6.6%	4.2%
Хотын хөгжил	1.9%	2.2%	4.2%	7.7%	11.1%
Харилцаа холбоо	1.8%	0.1%		0.0%	0.4%
Дэд бүтэц	1.8%	0.7%	1.0%	-0.1%	0.0%
Худалдаа, эдийн засаг	1.5%	8.7%	4.3%	2.2%	5.6%
Нийгмийн хамгаалал	1.4%	1.3%	1.3%	3.1%	10.7%
Бусад	1.1%	0.0%		2.3%	8.5%
Санхүүгийн салбар	0.4%	0.1%	0.3%	0.9%	2.7%
Төрийн удирдлага	0.2%	0.6%	0.1%	0.9%	0.9%
Ус хангамж, хотын дэд бүтэц	0.1%	1.2%	3.3%	5.0%	17.9%
Аж үйлдвэр			0.2%	3.4%	1.3%
Аялал жуулчлал				0.1%	0.2%

Хавсралт 3. 2018-2020 онд тухайн жилийн төсвийн тухай хуулиар баталсан төсвийг хэтрүүлэн ашигласан төсөл, арга хэмжээний жагсаалт

БОАЖЯ:

- 2019 онд АХБ-ны санхүүжилттэй Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл 0.5 тэрбум төгрөгөөр,

БХБЯ:

- АХБ-ны санхүүжилттэй Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл 2018 онд 7.2 тэрбум төгрөгөөр, 2019 онд 1.7 тэрбум төгрөгөөр, 2020 онд 1.3 тэрбум төгрөгөөр;
- АХБ-ны санхүүжилттэй Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл (тусгай болон энгийн) 2018 онд 6.9 тэрбум төгрөгөөр, 2019 онд 2.6 тэрбум төгрөгөөр;

БШУЯ:

- АХБ-ны санхүүжилттэй Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл 2.1 тэрбум төгрөгөөр;

ЗГХЭГ:

- Дэлхийн банкны санхүүжилттэй Ухаалаг засаг төсөл 2020 онд 0.5 тэрбум төгрөгөөр;
- БНХАУ-ын санхүүжилттэй Улаанбаатар-Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам барих төсөл болон төслийн зөвлөх 2018 онд 48.3 тэрбум төгрөгөөр, 2019 онд 68.2 тэрбум төгрөгөөр;
- ЖАЙКА⁴⁰-ын санхүүжилттэй Шинэ нисэх буудал 2 төсөл 2018 онд 0.9 тэрбум төгрөгөөр, 2019 онд 17.3 тэрбум төгрөгөөр;
- АХБ-ны санхүүжилттэй Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын хөтөлбөр – Төсөл-2 2019 онд 5.6 тэрбум төгрөгөөр, 2020 онд 4.4 тэрбум төгрөгөөр;
- АХБ-ны санхүүжилттэй Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл 2019 онд 0.06 тэрбум төгрөгөөр;

НЗДТГ:

- БНХАУ-ын санхүүжилттэй Яармагийн шинэ гүүр барих болон хуучин гүүрийг сэргээн засварлах төсөл 15.4 тэрбум төгрөгөөр;
- ЕХОБ-ны санхүүжилттэй Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл 2018 онд 6.9 тэрбум төгрөгөөр, 2019 онд 9.6 тэрбум төгрөгөөр;
- АХБ-ны санхүүжилттэй Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - төсөл 1 (тусгай болон энгийн) 2018 онд 11.2 тэрбум төгрөгөөр; 2019 онд 9.1 тэрбум төгрөгөөр, 2020 онд 10.1 тэрбум төгрөгөөр;
- Дэлхийн банкны санхүүжилттэй Улаанбаатар цэвэр агаар төсөл 2018 онд 0.6 тэрбум төгрөгөөр, 2020 онд 3.2 тэрбум төгрөгөөр;
- АХБ-ны санхүүжилттэй Гачуурт уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто зам барих төсөл 2019 онд 17.4 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилттэй Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл 2020 онд 0.4 тэрбум төгрөгөөр,

⁴⁰ Японы олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага

Сангийн яам:

- АХБ-ны санхүүжилттэй Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл 2019 онд 1.8 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилттэй Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл 2019 онд 0.8 тэрбум, 2020 онд 0.4 тэрбум төгрөгөөр,

ХХААХҮЯ:

- АХБ-ны санхүүжилтэй Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлэх, ажлын байрыг бий болгох төсөл 2018 онд 11.6 тэрбум, 2019 онд 17.4 тэрбум, 2020 онд 1.2 тэрбум төгрөгөөр,
- Дэлхийн банкны санхүүжилттэй Экспортыг хөгжүүлэх төсөл 0.6 тэрбум төгрөгөөр,
- БНХАУ-ын Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл 2018 онд 19.3 тэрбум, 2019 онд 18.5 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилтэй Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл 2019 онд 1.1 тэрбум, 2020 онд 18.6 тэрбум төгрөгөөр,
- Дэлхийн банкны санхүүжилтэй Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл 2020 онд 1.6 тэрбум төгрөгөөр,

ХНХЯ:

- АХБ-ны санхүүжилтээр Хүнс, тэжээл нийгмийн халамжийн төсөл /Нэмэлт санхүүжилт/ 2018 онд 1.9 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилтээр Хөдөлмөр эрхлэх ур чадварыг сайжруулах төсөл 2019 онд 1.5 тэрбум, 2020 онд 1.9 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилтээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл 2019 онд 0.3 тэрбум, 2020 онд 1.9 тэрбум төгрөгөөр,
- Дэлхийн банкны санхүүжилттэй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл 2020 онд 2.5 тэрбум төгрөгөөр,
- Дэлхийн банкны санхүүжилттэй Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл 2020 онд 2.8 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилтээр Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 0.16 тэрбум төгрөгөөр,

ЭМЯ:

- БНСУ-ын санхүүжилттэй Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн төсөл 2018 онд 30.2 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилттэй Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл-5 2018 онд 16.7 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл-Яаралтай тусламжийн төсөл 2020 онд 4.9 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилттэй Эрүүл мэндийн салбарын хөгжил төсөл-4 2018 онд 5.4 тэрбум төгрөгөөр, 2020 онд 1.0 тэрбум төгрөгөөр,
- Австри улсын санхүүжилттэй Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг төсөл 2018 онд 4.9 тэрбум төгрөгөөр,
- БНХАУ-ын санхүүжилттэй Цахим эрүүл мэнд төсөл 2018 онд 1.9 тэрбум төгрөгөөр,
- Австри улсын санхүүжилттэй Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх -2 шат” төсөл 2019 онд 6.2 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилттэй Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 үе шат 1.4 тэрбум төгрөгөөр,

ЭХЯ:

- БНХАУ-ын санхүүжилттэй Улаанбаатар-Мандалговь цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих төсөл 2018 онд 109.3 тэрбум төгрөгөөр,
- БНХАУ-ын санхүүжилттэй Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын шинэчлэл төсөл 2018 онд 35.9 тэрбум төгрөгөөр,
- Дэлхийн банкны санхүүжилттэй Эрчим хүчний салбар-2 2018 онд 2.8 тэрбум, 2020 онд 1.5 тэрбум төгрөгөөр,
- ХБНГУ-ын санхүүжилттэй Эрчим хүчний үйл ажиллагаа /Дархан ДЦС/ төсөл 2018 онд 0.5 тэрбум төгрөгөөр,
- АХБ-ны санхүүжилттэй Сэргээгдэх эрчим хүчийг нэмэгдүүлэх төсөл 2019 онд 0.5 тэрбум төгрөгөөр,

ОБЕГ:

- Польш улсын санхүүжилттэй Гамшиг, ослын үед үүрэг гүйцэтгэх хээрийн эмнэлгийн төсөл 0.7 тэрбум төгрөгөөр тус тус илүү ашиглалт гарсан байна.

Хавсралт 4. Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн байдал /сая төгрөг/

САЛБАР	2018 ОН		2019 ОН		2020 он	
	Үндсэн	Хүүгийн	Үндсэн	Хүүгийн	Үндсэн	Хүүгийн
Зам, тээврийн салбар	2,332.80	651.8	445.4	4,341.5	1,522.6	4,681.7
ОСНААҮ-ий салбар	319.3	434.6	53.7	427.2	8,543.5	460.5
Санхүү, эдийн засгийн салбар /ЖДҮ/	14,018.3	1,932.8	14,244.1	3,574.4	79,812.4	20,994.5
Бусад	-	-	-	-	24,145.1	-
Уул уурхай	1,089.2	1,409.3	4,226.9	789.3	146.9	727.1
Харилцаа холбоо	1,854.8	1,051.6	717.2	377.0	3,530.9	1,581.1
Хөдөө аж ахуй	3,079.9	1,826.0	1,403.2	1,750.2	8,603.3	3,730.4
Эрчим хүч	12,648.9	5,652.6	13,194.3	4,807.7	13,120.2	11,169.4
Нийт дүн	35,343.2	12,958.7	34,284.8	16,067.3	139,424.9	43,344.7

Хавсралт 5. Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлсэн эргэн төлөгдөөгүй зээлийн 2020 оны жилийн эцсийн үлдэгдэл

№	Эцсийн зээлдэгч	Төслийн нэр	Он	Валют	Эцсийн үлдэгдэл		
					Үндсэн валют	Ханш	Төгрөг
1	Эрчим хүчний яам	Тайширын усан цахилгаан станц байгуулах төсөл	2005	AED	47,749,000.0	775.8	37,042,241,730.0
2	Эрчим хүчний яам	Эгийн голын усан цахилгаан станцын төсөл	1992	USD	3,841,484.2	2,849.5	10,946,347,500.3
3	ОСНААҮГ	Улаанбаатар хотын дулааны үр ашгийг дээшлүүлэх төсөл	1997	MNT	234,451,425.4	1.0	234,451,425.4
4	ОСНААҮГ	Улаанбаатар хотын дулааны үр ашгийг дээшлүүлэх төсөл	1997	USD	15,224,912.8	2,849.5	43,383,541,272.7
5	Баян-Өлгий ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл	1998	MNT	991,058,656.0	1.0	991,058,656.0
6	Ховд аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл	1998	MNT	928,343,809.0	1.0	928,343,809.0
7	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл	1998	MNT	1,433,939,592.9	1.0	1,433,939,592.9
8	Увс аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл	1998	MNT	945,568,200.0	1.0	945,568,200.0
9	Завхан аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл	1998	MNT	1,304,445,614.2	1.0	1,304,445,614.2
10	Авто замын газар	Автозамыг хөгжүүлэх II төсөл	2000	SDR	15,394,603.4	4,104.1	63,180,375,824.6
11	Анод банк	Орон сууцны санхүүжилт төсөл	2001	MNT	2,648,402,418.0	1.0	2,648,402,418.0
12	Багануур ЗДТГ	Орон сууцны санхүүжилт төсөл	2001	MNT	209,180,000.0	1.0	209,180,000.0
13	Нийслэлийн ЗДТГ	Орон сууцны санхүүжилт төсөл	2001	MNT	826,133,277.0	1.0	826,133,277.0
14	Хэнтий аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	2,040,224,283.3	1.0	2,040,224,283.3
15	Дорноговь аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	1,841,366,587.7	1.0	1,841,366,587.7
16	Дундговь аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	2,191,892,416.1	1.0	2,191,892,416.1
17	Өмнөговь аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	1,102,213,269.7	1.0	1,102,213,269.7
18	Сүхбаатар аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	3,068,365,138.6	1.0	3,068,365,138.6
19	Дорнод аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	3,411,225,232.9	1.0	3,411,225,232.9
20	Булган аймгийн ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	1,727,686,618.0	1.0	1,727,686,618.0
21	Архангай ЗДТГ	Нийтийн аж ахуй, үйлчилгээг өргөтгөн хөгжүүлэх төсөл	2002	MNT	2,110,714,106.4	1.0	2,110,714,106.4
22	Кредит монгол ХХК	Кредит монгол зээл	2001	MNT	69,911,828.9	1.0	69,911,828.9
23	БХБЯ	Орон сууцны хороолол, дэд бүтцийн төсөл	2002	USD	70,489,016.0	2,849.5	200,859,155,982.2
24	Архангай ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	118,293,186.8	1.0	118,293,186.8
25	Капитал банк	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	3,543,641,303.3	1.0	3,543,641,303.3
26	Булган аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	2,531,556,582.3	1.0	2,531,556,582.3
27	Дундговь аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	1,887,505,777.6	1.0	1,887,505,777.6
28	Говь-Алтай аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	4,626,402,673.8	1.0	4,626,402,673.8
29	НЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	2,568,528,825.0	1.0	2,568,528,825.0
30	Орхон аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	7,446,709,838.3	1.0	7,446,709,838.3
31	Сүхбаатар аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	1,325,686,276.4	1.0	1,325,686,276.4
32	Төв аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	2,071,087,691.0	1.0	2,071,087,691.0
33	Өвөрхангай аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	9,862,792,666.8	1.0	9,862,792,666.8
34	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Хот байгуулалтын салбарын хөгжил төсөл	2002	MNT	443,351,987.8	1.0	443,351,987.8
35	Авто замын газар	Тээврийг хөгжүүлэх төсөл	1994	SDR	6,529,426.9	4,104.1	26,797,159,845.3
36	Авто замын газар	Тээврийг хөгжүүлэх төсөл	1994	SDR	7,513,818.7	4,104.1	30,837,162,650.8
37	НЗДТГ	Хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр - Төсөл 1 (Энгийн үйл ажиллагаа)	2017	USD	194,738.0	2,849.5	554,907,764.4

Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

38	НЗДТГ	Хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр - Төсөл 1 (Тусгай үйл ажиллагаа)	2017	SDR	2,045,616.6	4,104.1	8,395,333,263.4
39	НЗДТГ	Улаанбаатар хотын нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл	1997	SDR	11,410,781.4	4,104.1	46,830,531,471.4
40	НЗДТГ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 1(Энгийн үйл ажиллагаа)	2014	USD	20,629,056.7	2,849.5	58,782,703,328.7
41	НЗДТГ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 1(Тусгай үйл ажиллагаа)	2014	USD	16,922,143.4	2,849.5	48,219,816,782.7
42	Дархан-Уул аймгийн ЗДТГ	Дархан хотын бохир усны менежмент төсөл (Энгийн үйл ажиллагаа)	2016	USD	5,342,373.2	2,849.5	15,223,145,771.6
43	Дархан-Уул аймгийн ЗДТГ	Дархан хотын бохир усны менежмент төсөл (Тусгай үйл ажиллагаа)	2016	SDR	6,133,716.5	4,104.1	25,173,140,497.9
44	Алтай улиастай эрчим хүч	Эрчим хүчний төсөл	2001	MNT	668,686,782.6	1.0	668,686,782.6
45	Даланзадгад ДЦС	Эрчим хүчний төсөл	2001	MNT	356,654,135.0	1.0	356,654,135.0
46	Ховд цахилгаан ХХК	Эрчим хүчний төсөл	2001	MNT	1,752,644,540.9	1.0	1,752,644,540.9
47	Баян Өлгий цахилгаан шугам сүлжээ	Эрчим хүчний төсөл	2001	MNT	2,136,587,736.7	1.0	2,136,587,736.7
48	Увс цахилгаан түгээх сүлжээ ХХК	Эрчим хүчний төсөл	2001	MNT	2,044,048,037.1	1.0	2,044,048,037.1
49	НЗДТГ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 2(Энгийн үйл ажиллагаа)	2018	USD	6,579,580.1	2,849.5	18,748,579,205.3
50	НЗДТГ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Төсөл 2(Тусгай үйл ажиллагаа)	2019	USD	7,842,568.8	2,849.5	22,347,478,135.8
51	Булган аймгийн ЗДТГ	Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн - нэмэлт санхүүжилт	2019	USD	2,447,465.3	2,849.5	6,974,076,818.5
52	Дундговь аймгийн ЗДТГ	Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн - нэмэлт санхүүжилт	2019	USD	1,877,528.2	2,849.5	5,350,035,238.7
53	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн - нэмэлт санхүүжилт	2019	USD	2,595,141.2	2,849.5	7,394,880,829.3
54	Сүхбаатар аймгийн ЗДТГ	Зүүн өмнөд Говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн - нэмэлт санхүүжилт	2019	USD	857,620.4	2,849.5	2,443,797,849.0
55	НЗДТГ	Улаанбаатар хотын нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх төсөл II	2004	SDR	11,993,392.8	4,104.1	49,221,603,490.6
56	Архангай ЗДТГ	Архангай ядуурлыг бууруулах төсөл	1996	MNT	5,100,002.6	1.0	5,100,002.6
57	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Архангай ядуурлыг бууруулах төсөл	1996	MNT	108,183,897.8	1.0	108,183,897.8
58	ЗТХЯ	Дархан-Эрдэнэт авто зам барих төсөл	1996	KWD	4,067,863.2	9,344.5	8,012,107,087.2
59	Эрчим хүчний яам	Тайширын усан цахилгаан станц байгуулах төсөл	2002	KWD	6,174,756.5	9,344.5	57,699,949,992.9
60	НЗДТГ	Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр - Европын Хөрөнгө оруулалтын банкаас санхүүжих	2014	EUR	21,000,000.0	3,495.8	73,411,380,000.0
61	НЗДТГ	УБ-хотын гэр хорооллыг хөгжүүлэх төсөл-2	2014	EUR	3,652,803.2	3,495.8	12,769,396,510.3
62	Баруун бүсийн эрчим хүч ХХК	БАРУУН БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК	2003	MNT	31,940,763,400.0	1.0	31,940,763,400.0
63	Орхон аймгийн ЗДТГ	Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх төв байгууламжийг өргөтгөх төсөл	2008	EUR	9,159,726.9	3,495.8	32,020,389,962.7
64	Даланзадгад ДЦС	Эрчим хүч үүсгэх цахилгаан станц барих төсөл (Даланзадгад)	1997	MNT	4,949,787,369.0	1.0	4,949,787,369.0
65	Даланзадгад ДЦС	Эрчим хүч үүсгэх цахилгаан станц барих төсөл (Даланзадгад) II	2000	KRW	933,741,300.0	2.6	2,455,739,619.0
66	Төрийн мэдээлэл холбоо	Төрийн холбооны сүлжээг сайжруулах төсөл	2000	KRW	6,958,685,060.0	2.6	18,301,341,707.8
67	УБ Төмөр зам ХНН	Төмөр замын шинэчлэлтийн төсөл	1993	JPY	2,313,261,148.9	27.6	63,799,742,487.5
68	УБ Төмөр зам ХНН	Төмөр замын шинэчлэлтийн төсөл II	1995	JPY	3,180,467,266.4	27.6	87,717,287,207.0
69	Шивээ-Овоо ТӨХК	Багануур, Шивээ Овоо нүүрсний уурхайг хөгжүүлэх төсөл	1997	MNT	22,518,606,327.3	1.0	22,518,606,327.3
70	Шивээ-Овоо ТӨХК	Багануур, Шивээ Овоо нүүрсний уурхайг хөгжүүлэх төсөл II	1998	MNT	36,677,271,890.8	1.0	36,677,271,890.8
71	Тээврийн Хэрэгсэл	Тээврийг хөгжүүлэх төсөл	2001	SDR	1,439,754.0	4,104.1	5,908,836,842.3
72	Монголын Төмөр Зам ТӨХК	Хөдөлгөх бүрэлдэхүүн нийлүүлэх төсөл	2012	USD	28,588,400.0	2,849.5	81,462,931,684.0
73	Ус суваг ашиглалтын газар	Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн төсөл	2002	EUR	9,464,596.0	3,495.8	33,086,145,404.9
НИИТ							1,402,020,277,161.6

Хавсралт 6. Эрүүл мэндийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, үр дүн /сая төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эмнэлгийн тоног төхөөрөмж			Эмнэлгийн хэрэгсэл	
		Нэр төрөл	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 5 төсөл	Амьсгалын аппарат	32	3,038.2	481	279.3
		Өвчтөний хяналтын монитор	43			
		Рентген аппарат	16			
2	Ковид-19 эсрэг яаралтай хариу арга хэмжээ авах төсөл	Компьютер томограф аппарат	1	338.6		
3	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 5 төсөл -Яаралтай тусламжийн төсөл	Амьсгалын аппарат	288	28,029.0	69,090	526.1
4	Ази номхон далайн гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах сангийн буцалтгүй тусламж	Молекул биологийн лабораторийн тоног төхөөрөмж	371	4,267.5		
		RT-PCR болон автомат шинжилгээний дээж ялгах төхөөрөмж	50,012			
5	Цахим эрүүл мэнд төсөл	Зөөврийн рентген аппарат	27	5,930.6		
		Зөөврийн эхо аппарат	41			
6	Монгол Улсад COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	ЕСМО аппарат	1	13,217.2		
		Бөөр орлуулах эмчилгээний төхөөрөмж	3			
		Гемодиализийн аппарат	21			
		Яаралтай тусламжийн тэргэнцэр, амь тэнцсэн үеийн тоног төхөөрөмжийн хамт-50ш	50			
		Дурангийн оношилгооны иж бүрдэл	11			
		Цогцос хадгалах хөргөгч	21			
		Тусгаарлах тоног төхөөрөмж	30			
		Мэс заслын таазны төхөөрөмж	10			
		Өвчтөний монитор	30			
		Капнограф монитор, БИС монитор	30			
		ЭМГ аппарат	1			
		Дурангийн ариутгалын төхөөрөмж	6			
		Эхо аппарат	7			
		ПГУ аппарат	2			
		Хүчилтөрөгчийн баллон, тоног төхөөрөмж	153			
		Яаралтай тусламжийн, сэхээн амьдруулах тоног төхөөрөмж	73			
		Лабораторийн ариутгалын тоног төхөөрөмж	13			
		Гал тогоо, угаалгын тоног төхөөрөмж	3,153			
		Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж	72			
		7	Монгол Улс дахь КОВИД-19 төсөл (Цар тахлын онцгой байдлын санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд олгох буцалтгүй тусламж)			
НИЙТ ДҮН			54,518	54,821.1	4,570,104	3,512.0